Агуулга

Геодези, зураг зүй

Суурь судалгаа, мониторинг

Газар зохион байгуулалт

Кадастр

Орон зайн мэдээлэл, технологи

Архив, мэдээллийн төв

Хот байгуулалт

Хот байгуулалтын кадастр

Төрийн захиргаа, удирдлага

Бусад

Ковид -19

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙ

Геодезийн байгын цэг тэмдэгтийн хадгалалт, хамгаалалт тооллого судалгааны талаар:

Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт байрлах геодезийн байнгын цэг тэмдэгтийн тооллого судалгаа хийх ажлын төлөвлөгөө гарган байгууллагын даргаар баталуулсан.

Аймгийн Засаг даргын 2016 оны А/228 дугаар захирамжаар “Орон нутагт байгаа геодезийн байнгын цэг тэмдэгтийн үзлэг тооллогын ажлын хээрийн судалгаа, тооллогын ажилд шаардагдах зардлыг байгууллага тус бүрийн төсвөөс тооцон гаргахыг үүрэг болгосоны дагуу цэг тэмдэгтийн хээрийн судалгаа тооллогын ажилд шаардагдах зардлын тооцоог гаргаж 2020 оны 06 сарын 29-ны өдөр Орхон суманд №538 , Хонгор суманд №539, Дархан суманд №537, Шарын гол суманд №540 ттот албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Үүний дагуу Шарын гол сум 30 л, Орхон сум 20 л, Дархан сум 287л, Хонгор сум 57л шатахууныг гаргаж өгсөн.

Хуучин цэгийн судалгаа, тооллого хийх ажлын хүрээнд Дархан сумын нутаг дэвсгэрт байрлах триангуляцийн **1**, өндрийн **1**, гравиметрийн **1**, GPS-ийн **24,** полигонометрийн **22** нийт **52** цэг тэмдэгтийг 2020 оны 09 сарын 14-нээс 10 сарын 22-ны өдрүүдэд.

Хонгор сумын нутаг дэвсгэрт байрлах триангуляцийн **44**, өндрийн **9**, GPS-ийн **7** нийт **60** цэг тэмдэгтийг 2020 оны 10 сарын 22-30-ны өдрүүдэд.

Орхон сумын нутаг дэвсгэрт триангуляцийн **1**, өндрийн **1**, гравиметрийн **1**, GPS-ийн **9** нийт **12** цэг тэмдэгтийг 2020 оны 09 сарын 07-09-ны өдрүүдэд.

Шарын гол суманд байрлах триангуляцийн **1** GNSS-ийн сүлжээний **4** нийт **5** цэг тэмдэгтийг 2020 оны 09 сарын 03-04-ны өдрүүдэд газар дээр нь явж тооллого судалгаанд хамруулаа.

Цэг тэмдэгтийн тооллогыг нэгтгэн Spark-аар ГЗЗХ-ийн мэргэжилтэн Алимаад хүргүүлсэн. /Хавсралт-1/

Цэг тэмдэгтийн тооллогын ажлын тайланг сум тус бүрээр бичиж дамалуудад хүлээлгэн өгсөн.

Байнгын ажиллагаатай станц /CORS/ талаар:

Сүлжээний холболтыг хэви йн байдалд шилжүүлэх, төв серверт өгөгдөл дамжуулах асуудлыг шийдвэрлэхээр дараахь арга хэмжээг зохион байгуулж ажиллаа. Дархан суманд байрлах GNSS-ийн байнгын ажиллагаатай станц төв серверт өгөгдөл дамжуулахгүй байгааг засахын тулд ГЗБГЗЗГ-ын мэргэжилтэн Сумъяатай холбогдож 2020 оны 02 сарын 07-ны өдөр байнгын ажиллагаатай станц дээр мэргэжилтэн Ч.Анхбаярын хамт очиж тохиргоо хийж хэвийн ажиллагаанд оруулсан.

Хонгор суманд байрлах гравиметрийн цэг 035 дээр бодит агшины хэмжилт хийж үр дүнг ГЗБГЗЗГ-ын ГЗЗХэлтсийн мэргэжилтэн В.Отгонбаярт хүргүүлсэн.

ГЗБГЗЗГ-аас ирсэн 1/2901 албан бичгийн дагуу Дархан суманд байрлах GNSS-ийн дэд сүлжээний 12-24 цагийн хэмжилт хийсэн 811 цэг дээр багаж байрлуулж 2013-2017 онд хэмжигдсэн байршлын хувьд өөрчлөлт ороогүй 10 объект, геодезийн 5-н цэг, дулааны болон ариутгах татуургын 10 худаг, байнгын ажиллагаатай станц ашиглан 2-3 объект, геодезийн 6 цэгт штатив ашиглан бодит агшины хэмжилт хийж үр дүнг хүргүүллээ.

Байр зүйн зураглалын болон гүйцэтгэлийн зураг, шугам сүлжээ инженер геодезийн ажлуудыг шалгаж хүлээн авсан талаар:

Геодези, зураг зүй, кадастрын зураглалын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй "Гео од" "Гео глоб мэп" , "Ёлт сүрвэй" ХХК -ийн хийж гүйцэтгэсэн **90** ажлыг шалгаж хүлээж авсаны **32** ажил нь барилга байгууламж, шугам сүлжээний гүйцэтгэлийн зураг, **57** тэг тэнхлэгийг газарт шилжүүлсэн ажлууд байна. /Хавсралт-1/

Гүйцэтгэлийн зураглалын **32** ажлын **13** нь барилга байгууламж, орон сууц, **20** нь зам, талбай, инженерийн шугам сүлжээний гүйцэтгэл байна.

Хүлээн авсан **32** гүйцэтгэл, шугам сүлжээ, хорооллын зам, ногоон байгууламжийг байр зүйн зургийн 192.168.10.37 серверт хандан баяжуулалт хийж орууллаа.

Газар зүйн нэрийг зөв нэрлэж хэвшүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах ажлыг зохион байгуулах талаар:

Газар зүйн нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлын хүрээнд Хонгор, Орхон сумын 1:100 000 масштабтай газар нутгийн нэрийн зураг, 1:100 000 масштабтай байр зүйн зургийг давхцуулан Дархан, Хонгор, Орхон, Шарын гол сумдын нутаг дэвсгэрт байрлах уул, толгой, даваа, хөтөл, тохойны **529**, ам, хошуу сайр, хөндийн **306** газар зүйн нэрийг мэдээлийн санд бүртгэлээ. Газар зүйн нэрийн мэдээллийн сангийн гүйцэтгэлийг 12 сарын 8 нд ГЗЗХ-ийн мэргэжилтэн Д.Ундармаад цахимаар хүргүүлсэн.







Орон нутагт “Газар зүйн нэрийн салбар зөвлөл” байгуулах тухай ГЗБГЗЗГ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу Дархан-Уул аймагт газар зүйн нэрийн салбар зөвлөл байгуулах Засаг даргын захирамжийн төсөл, салбар зөвлөлийн дүрэм, 2020 онд газар зүйн нэрийн тодоруулалт хийхэд гарах зардлын төсвийг гарган /№100 тоотоор/, Дархан, Хонгор, Орхон, Шарын гол сумдад хийгдэх хаягийн самбар, тэмдгийг үйлдвэрлэх байршуулах ажлын төсвийг гарган /№101тоотоор/ ХОХБТХ-т хүргүүлсэн.

“Газар зүйн нэрийн салбар зөвлөл” байгуулах тухай Засаг даргын захирамжийн төслийг бэлтгэж ХОХБТХ-т хүргүүлсэний дагуу Дархан-Уул аймгийн Засаг даргын 2020 оны 03 сарын 03-ны өдрийн 01-А/78 дугаар захирамж гарч Дархан-Уул аймгийн “Газар зүйн нэрийн салбар зөвлөл”-ийг байгуулсан.

Хонгор сум 2019 оны 12 сарын 25-ны 258, Орхон сум 2019 оны 12 сарын 23-ны А/203, Шарын гол сум, Дархан сум 2019 оны 12 сарын 26-ны А/290 дугаар захирамжууд гаргаж “Газар зүйн нэрийн салбар зөвлөл” байгуулсан.

Дархан-Уул аймгийн Засаг даргын 2020 оны 03 сарын 03-ны өдрийн 01-А/78 дугаар захирамжар байгуулагдсан “Газар зүйн нэрийн салбар зөвлөл”-ийн 2020 онд хийх ажлын төлөвлөгөө боловсруулаж салбар зөвлөлийн 18 гишүүн байгууллагаас санал авахаар хүргүүлсэнээс 4-н байгууллагаас /Авто тээврийн төв, МХСТӨХК, Хүнс хөдөө аж ахуйн газар, Мэргэжлийн хяналтын газар/ хариу ирүүлсэн байна.

Салбар зөвлөлийн хурлыг зохион байгуулахаар салбар зөвлөлийн даргад санал хүргүүлсэн боловч онцгой байдал зарлагдсантай холбоотойгоор хойшлогдоод байна.

Өмчлөлийн газраа өвлүүлсэн, худалдсан **18** иргэний эрх шилжих бүртгэлийг хийж эзэмшил, ашиглалтын газартай **77** иргэн, аж ахуйн нэгжид кадастарын зураг гаргаж үйлчилсэн.

Хаяг дугаар олгох, хаягийн зургийг хэрэглээнд нэвтрүүлэх талаар:

Шинэ хаягийн зургийн дагуу **303** иргэн, **53** аж ахуйн нэгжийн эзэмшил газар, үл хөдлөх хөрөнгөд хаяг дугаар олгосон. / Хавсралт 2/

Дархан сумын 8 дугаар баг Эх орончдын 1 дүгээр гудамж “Дархан ус суваг” ТӨХК , “Цагдаагийн газар” , “Онцгой байдлын газар”, ШШГАлба, 14 дүгээр баг Дэвшлийн 12, 13 дугаар гудамж 28-н иргэн, 5 дугаар баг Худалдааны 2 дугаар гудамж 30 иргэн, аж ахуйн нэгж, 5 дугаар баг Атарчдын 2 дугаар гудамж 28 иргэн, аж ахуйн нэгж, 9, 12 дугаар багт багийн хөгжлийн төв, иргэн Б.Цэдэндамба, 15 дугаар баг Үндэсний эрх чөлөөний 5

дугаар гудамж “Дэлгэрэх бат дэвжих”, “Өргөх ноён” ХХК, 13 дугаар баг Үйлдвэрчний 5 дугаар гудамж “Триконтинент” ХХК, Үйлдвэрчний 6 дугаар гудамж иргэн Н.Ганбат, 8, 9, 10 12 дугаар баг Барилгачдын өргөн чөлөөний 1-41 дүгээр гудамжинд байрлах иргэн аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг, дугаар олгуулах тухай албан бичгийг Дархан сумын ИТХ-д 114 тоотоор хүргүүлсэн.

2020 оны 02 сарын 20 нд Дархан сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралд оролцож дээрхи иргэн аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг дугаар олгох тогтоол гаргуулсан.

Дархан сумын 14, 31 дүгээр хороололд шинээр төлөвлөгдсөн амины орон сууцны зариулалтаар олгох газрын хаяг дугаарыг Дархан сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар оруулж 21 дүгээр тогтоол гаргуулсан.

Дархан-Уул аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан “Ардын өргөн чөлөөний” 1, 2, 3 дугаар гудамжийг П.Дамдин агсаны нэрэмжит “Ардын өргөн чөлөөний” гудамж болгох. / 16-н давхарын урд уулзвараас аюулгүйн тойрог хүртлэх / саналыг ХОХБТХ-т 164 тоот албан бичгээр хүргүүлсэн. Үүний дагуу тухайн гудамжийг Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлын 2020 оны 05 дугаар сарын 14-ны 41 дүгээр тогтоолоор П.Дамдин агсаны нэрэмжит болгосон.

Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/73 дугаар тушаалаар батлагдсан “Хаягийн мэдээлэл шалгах, засварлах, зэрэгцүүлэн хаягийн мэдээлэл үүсгэх ажлын удирдамж” , 2020 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/85 дугаар тушаалаар баталагдсан тэргүүний ГХБХБГ-ыг шалгаруулах уралдааны удирдамжийг Орхон, Хонгор, Шарын гол сумдын газрын даамалуудад 296 тоотоор хүргүүлсэн.

ГЗБГЗЗГ-ын даргын 2020 оны А/73 дугаар тушаалын дагуу “Хаягийн мэдээлэл шалгах, засварлах, зэрэгцүүлэн хаягийн мэдээлэл үүсгэх ажлыг хийж гүйцэтгэх ажлын хэсэг байгуулах захирамжийн төслийг бэлтгэж ХОХБТХ-ийн мэргэжилтэн Отгончимэдэд хүргүүлсэн.

“Хаягийн мэдээлэл шалгах, засварлах, зэрэгцүүлэн хаягийн мэдээлэл үүсгэх ажлын удирдаж”-ын дагуу аймгийн Засаг даргын 2020 оны 04 сарын 16-ны өдрийн 01-А/146 дугаар захирамжаар тухайн ажлыг хийж гүйцэтгэх ажлын хэсгийг байгуулсан.

Хаягийн мэдээлэл шалгах, засварлах, зэрэгцүүлсэн хаягийн мэдээлэл үүсгэх ажлын удирдамж”-ийн дагуу Дархан суманд хийсэн ажлын материалыг info@gazar.gov.mn хаягаар ГЗБГЗЗГ-ын ГЗЗХ-т явуулсан.

“Хаягийн мэдээлэл шалгах, засварлах, зэрэгцүүлэн хаягийн мэдээлэл үүсгэх ажлын удирдаж”, тэргүүний ГХБХБГ-ыг шалгаруулах уралдааны удирдамжийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг гаргаж баталуулсан. Орхон, Хонгор, Шарын гол сумдын газрын даамалуудад төлөвлөгөөний дагуу хийх ажлын зааварчилгаа өгсөн.

Иргэн аж ахуйн нэгжийн эзэмшилд байгаа үл хөдлөх эд хөрөнгө, Дархан сумын нутаг дэвсгэрт байрлах нийтийн орон сууцны орц, гарцыг хаягийн мэдээллийн санд оруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Шуудангийн нэгдсэн кодын шинэчлэл хийх ажлын хүрээнд Харилцаа холбооны зохицуулах хорооноос ирсэн албан бичгийн дагуу Дархан, Хонгор, Орхон, Шарын гол сумдын хаягийн зургийг / odkhuu@crc.gov.mn /явуулсан.

Дархан сумын хувьд нийтийн орон сууцны барилга нилээд баригдаж байгаатай холбоотой СӨХ-ийн орчны газрын талбайн хэмжээнд өөрчлөлт орсон тохиолдол бүрт ГХБХБГ-т мэдэгдэж хяналтын хэмжилт хийлгэх, газар ашиглалтын гэрчилгээг шинэчлүүлэх ажлуудыг хийж гүйцэтгэх, газар ашиглуулах тухай Аймгийн Засаг даргын захирамж гарсан боловч гэрээ хийгээгүй байгаа 11-н СӨХ гэрээ хийх тухай албан бичгийг Дархан-Уул аймгийн СӨХ-ны салбар зөвлөлд хүргүүлсэн. / 176 тоотоор/ Кадастрын хэмжилт зураглалын компианууудаар хашаа байшингаа хэмжүүлсэн **75** иргэний материалыг хүлээн авч мэдээллийн санд оруулсан.

СУУРЬ СУДАЛГАА, МОНИТОРИНГ

Суурь судалгаа мониторингийн чиглэлээр:

Газрын нэгдмэл сангийн 2019 оны Газарт учирсан хохиролын ГТ-6 тайлан, Газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний ГТ-7 тайланг аймгийн хэмжээнд нэгтгэж, ГЗБГЗЗГ-ын Суурь судалгаа, мониторингийн хэлтсийн мэргэжилтэн Д.Мөнхцэцэгт munkhtsetseg.do@gazar.gov.mn цахим шуудангаар 2020.01.08-ны өдөр хүргүүлсэн.

Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааг 2020 оны 12 сарын 10-ны өдрийн байдлаар аймгийн хэмжээнд 5 иргэн, 35 хуулийн этгээд хийлгэсэн.


"ГЕО ОД" ХХК

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

2020.04.15 № 01/327

2020.04.14 -ны № 04/30 -т

Дүгнэлт баталгаажуулсан тухай

Монгол Улсын "Газрын тухай хууль"-ийн 58 дугаар зүйл, Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам"-ын 3.6-д заасны дагуу дараах иргэн, ах эгч нарт, байгуулагдсан зохицлаар танай компаний хийж гүйцэтгэсэн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлыг дүгнэгдүүлж батлагаатуулан хүргүүлье.

Үүнд:

1. Дархан-Уул аймгийн Дархан сумынд байрлах нэгж талбарын 4506100261 дугаартай "Дархан таван нуур" ХХК-ийн эзэмшлийн бүх газар,
2. Дархан-Уул аймгийн Дархан сумынд байрлах нэгж талбарын 4506100260 дугаартай "Дархан таван нуур" ХХК-ийн эзэмшлийн бүх газар,
3. Дархан-Уул аймгийн Дархан сумынд байрлах нэгж талбарын 4506100258 дугаартай "Дархан таван нуур" ХХК-ийн эзэмшлийн бүх газар,
4. Дархан-Уул аймгийн Дархан сумынд байрлах нэгж талбарын 4506902703 дугаартай "Дархан таван нуур" ХХК-ийн эзэмшлийн бүх газар,
5. Дархан-Уул аймгийн Дархан сумынд байрлах нэгж талбарын 4506902704 дугаартай "Дархан таван нуур" ХХК-ийн эзэмшлийн бүх газар,
6. Дархан-Уул аймгийн Дархан сумынд байрлах нэгж талбарын 0801000615 дугаартай "Дархан имперс" ХХК-ийн эзэмшлийн бүх газар,
7. Дархан-Уул аймгийн Дархан сумынд байрлах нэгж талбарын 013100229 дугаартай "Дархан имперс" ХХК-ийн эзэмшлийн бүх газар,
8. Дархан-Уул аймгийн Дархан сумынд байрлах нэгж талбарын 4506302559 дугаартай "Гэрэл хан" ХХК-ийн эзэмшлийн бүх газар,
9. Дархан-Уул аймгийн Дархан сумынд байрлах нэгж талбарын 4506502846 дугаартай иргэн Б.Цогтбаатарын эзэмшлийн бүх газар.

0802000458

"ГЕО ОД" ХХК

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ ЧАНАРЫН ХЯНАН БАТАЛГАА, ГАЗРЫН КАДАСТР, ГЕОДЕЗИЙН ҮЙЛДВӨРЛӨЛ ҮЙЛЧИЛГЭЭ

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМ ИРГЭН Б.ЦОГТБААТАРЫН "ЦУУРАЙ ЦО-3" ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОРИУЛАЛТТАЙ ГАЗРЫН "ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ЗАХИАЛГАТ ХЯНАН БАТАЛГААА"-НЫ АЖИЛ

ДАРХАН 2020 ОН

Дархан-Уул аймгийн хүчтэй элэгдэл, эвдрэлд орсон нөхөн сэргээх шаардлагатай тариалангийн газрын судалгааг гаргаж ГЗБГЗЗГ-ын Суурь судалгаа мониторингийн хэлтэст 2020.04.01-ний өдрийн 276 тоот албан бичгээр хүргүүлсэн.


ДАРХАН-УУЛ АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР
45043 Дархан, Дархан-Уул аймаг 8-р баг
Утас/Факс: 7037-3770
E-mail: Darkhan@gazar.gov.mn
Веб хаяг: http://www.darkhan.gazar.gov.mn

2020.04.01 № 276

танай 2020.02.28 -ны № 1/563 -т

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН СУУРЬ СУДАЛГАА, МОНИТОРИНГИЙН ХЭЛТЭСТ

Дархан-Уул аймгийн хүчтэй элэгдэл, эвдрэлд орсон нөхөн сэргээх шаардлагатай тариалангийн газрын судалгааг хүргүүллээ.

Хавсралт 1,2 хуудастай.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Х.ОЛОНБАЯР

ТАЛДСЭН

D:\Цэндэз 2020 он\албан тоот\тоот А5.274.docx


1

Дархан-Уул аймгийн хүчтэй элэгдэл, эвдрэлд орсон нөхөн сэргээх шаардлагатай тариалангийн газрын судалгаа

2020.03.31

№	Аймаг	Сум	Нэгж талбарын дугаар	Талбай, га	Солбицол	Газар эзэмшигч, ашиглагч	Элэгдэл, эвдрэл төрөл	Аймаг, сум, дүүргийн санал
1	Дархан-Уул	Хонгор	450700015	443.8701	106.02714 49.556217 106.00416 49.535077 105.98311 49.53715 105.9827 49.53719 106.00868 49.561799 106.02714 49.556217	Залан Мянх ХХК	Салхины	Танилцулах эхлэл зохион байгуулахаар ажиллах байна.
2	Дархан-Уул	Хонгор	450700016	311.579	106.02269 49.534087 106.02252 49.533996 106.0149 49.534498 106.01037 49.534796 106.00613 49.534943 105.00472 49.535167 106.02515 49.55415 106.02694 49.555722 106.02687 49.555741 106.02708 49.555853 106.02726 49.555944 106.02749 49.556006 106.04323 49.552679 106.04326 49.552395 106.02389 49.535204 106.02269 49.534087	Залан Мянх ХХК	Салхины	Танилцулах эхлэл зохион байгуулахаар ажиллах байна.
3	Дархан-Уул	Хонгор	450700027	147.199	106.15558 49.521434 106.15502 49.519802 106.15219 49.520066 106.15134 49.520146 106.13527 49.521639 106.13662 49.529236 106.13689 49.529795 106.13707 49.529896 106.15817 49.528995 106.15575 49.521925 106.15558 49.521434	Гацуурт Агро ХХК	Салхины	Танилцулах эхлэл зохион байгуулахаар ажиллах байна.
4	Дархан-Уул	Хонгор	450700031	185.613	106.16883 49.491534 106.17437 49.502319 106.17882 49.507732 106.18871 49.507217 106.1737 49.483055 106.17365 49.482964 106.17364 49.482939 106.17356 49.482962 106.17327 49.483049 106.16575 49.485283 106.16883 49.491534	Гацуурт Агро ХХК	Усны	Танилцулах эхлэл зохион байгуулахаар ажиллах байна.
5	Дархан-Уул	Хонгор	450700032	318.4035	106.11862 49.484642 106.11853 49.484624 106.11854 49.484666 106.11896 49.486043 106.12527 49.504941 106.14774 49.504607 106.1429 49.490102 106.12494 49.485894 106.11862 49.484642 106.07884 49.473836	Гацуурт Агро ХХК	Усны	Танилцулах эхлэл зохион байгуулахаар ажиллах байна.

Eros_rate_Wat_eros

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

Байгалийн унаган төрх байдлыг алдагдуулж, хүрээлэн буй орчинд болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл ихээр үзүүлдэг уул, уурхайн зориулалтаар эзэмшүүлж, ашиглуулсан газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийх ажлыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас зохион байгуулж байгаатай холбогдуулан 2020 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн дотор тухайн сумын хэмжээнд байгаа уул уурхайн зориулалтаар олгогдсон нэгж талбарын судалгааг авахаар сумдын газрын даамлуудад аймгийн ГХБХБГ-ын даргын 2020.04.02-ны өдрийн 280 тоот албан бичгийг тус тус хүргүүлсэн.



ДАРХАН-УУЛ АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР
45643 Дархан, Дархан-Уул аймаг Хөх баг
Утас/Факс: 7037-3770
E-mail: Darkhan@garar.gov.mn
Веб хаяг: http://www.darkhan.garar.gov.mn

2020.04.17 № 330
тавай 2020.03.30 -ны № 1/912 -т

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР, СУУРЬ СУДАЛГАА, МОНИТОРИНГИЙН ХЭЛТЭСТ

Дархан-Уул аймгийн хэмжээнд уул уурхайн зориулалтаар олгогдсон нэгж талбарын судалгаа хүргүүллээ.
Хавсралт 2 хуудастай.

ГАЗРЫН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА НЯМДОРЖ

D:\Цэндээ 2020 он\албан тоот\тоот А5.330.docx

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН УУЛ УУРХАЙН ЗОРИУЛАЛТААР ОЛГОГДСОН НЭГЖ ТАЛБАРЫН СУДАЛГАА

2020.04.17

№	Эзэмшигч, ашиглагчийн нэр	Үндсэн ашигт малтмал	Захиргааны он, сар, өдөр, дугаар	Нэгж талбарын дугаар	Талбайн хэмжээ /га/	Хянан баталгаажуулах хийгдсэн эсэх
1	Шарын Гол ХК	Нүүрс	2018.09.26 А/124	4501001462	1767.19	Тийм
2	Бага Таван ХХК	Алт	2015.05.20 63	4501000890	61.5	Тийм
3	Хатантушиг ХХК	Алт	2015.06.27 122	4501000889	56.49	Тийм
4	Да ди эн Юувн ХХК	Алт	2010.06.15 171	4501000892	42.48	Үгүй
5	Баян Талын Өв ХХК	Алт			10.66	Үгүй
6	Их Өвөлжөө И Ё О Т ХХК	Алт	2005.09.15 178	4501001140	38.53	Үгүй
7	ЧНЕГ ХХК	Алт	2017.08.08 А/86	4501000001	55.08	Үгүй
8	Дархан Алтан Уул ХХК	Алт	2005.09.15 178	4501000930	31.97	Үгүй
9	Гурвэт ХХК	Алт	2018.06.18 А/83	4501000929	52.88	Үгүй
10	Лайтуурс ХХК	Алт	2009.05.25 100	4501000895	26.12	Үгүй
11	Шижир таалт ХХК	Алт	2013.08.23 169	4501000861	78.188	Үгүй
12	Асланполимет ХХК	Алт	2013.10.10 200	080402460	91.51	Үгүй
13	ЖМЭ ХХК	Алт	2011.09.27 108	4501000894	38	Үгүй
14	Да ди эн Юувн ХХК	Алт	2011.07.11 171	4501001149	21.17	Үгүй
15	Жанцаан Юнан ХХК	Алт	2010.06.05	080400029	48.18	Үгүй
16	Карьер ХХК	Түгээмэл тархацтай ашигт малтмал	2012.01.20 09	80250059	281.2	Үгүй
17	Сонголон хайрхан ХХК	Түгээмэл тархацтай ашигт малтмал	2015.10.25 184	4503003039	108	Үгүй
18	Анто од ХХК	Түгээмэл тархацтай ашигт малтмал	2019.07.25 А/132	4503004447	0.1469	Үгүй
19	Анто од ХХК	Түгээмэл тархацтай ашигт малтмал	2019.07.26 А/132	4503004449	9.65	Үгүй
20	Анто од ХХК	Түгээмэл тархацтай ашигт малтмал	2019.07.26 А/132	4503004450	80.9832	Үгүй
21	Дархан-Эрдэнэ бурэн ХХК	Түгээмэл тархацтай ашигт малтмал	2006.03.13 67	4502000514	19.8	Үгүй
22	Очир-Ундраа ХХК	Алт	2013.04.16 43	4502002211	188.4	Үгүй
23	Уулс ноён ХХК	Алт	2013.08.12 125	4502001354	180.85	Үгүй
24	Уулс ноён ХХК	Түгээмэл тархацтай ашигт малтмал	2019.06.19 128	4502004711	6.0	Үгүй
25	Альюс ХХК	Алт	2019.06.19 123	4502004720	6.48	Үгүй

Аймгийн Хүнс хөдөө, аж ахуйн газар аймгийн хэмжээнд үлийн цагаан огтонотой тэмцэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд Дархан сумын бэлчээрийн газрын зураг болон холбогдох цэгийн мэдээллийг Дархан сумын ЗДТГ-т хүргүүлсэн.





Дархан сумын бэлчээрийн талбайн координат

2020.04.07

Д/д	Талбайн хэмжээ	Газрын байршил	X	Y
0			567567.2498	5474702.578
1			567110.1759	5474419.412
2			567241.3529	5474453.086
3			567322.8997	5474473.983
4			567968.1282	5474646.203
5			567952.8229	5474596.443
6			567952.7547	5474596.212
7			567952.7035	5474596.002
8			567950.8587	5474589.7
9			567950.8357	5474589.591
10			567950.7865	5474589.299
11			567949.3106	5474578.598
12			567949.3065	5474578.568
13			567949.2744	5474578.243
14			567949.2595	5474578.155.155
15			567945.7644	5474506.025
16			567945.759	5474505.350
17			567945.5749	5474493.15
18			567945.0325	5474472.718
19			567941.8478	5474455.025
20			567913.5759	5474373.331
21			567833.2076	5474153.089
22			567833.17	5474152.983
23			567833.1612	5474152.866
24			567813.1809	5474093.015
25			567693.498	5473799.378
26			567693.4843	5473789.342
27			567663.06	5473690.006
28			567592.7963	5473490.236
29			567546.1918	5473366.69
30			567548.1605	5473366.5
31			567548.0692	5473366.201
32			567534.2943	5473315.365
33			567534.2908	5473315.351
34			567534.2308	5473315.102
35			567524.0638	5473267.546
36			567524.0492	5473267.476
37			567523.9959	5473267.154
38			567523.8854	5473267.077
39			567521.411	5473244.854
40			567518.5949	5473235.187
41			567227.4443	5472554.582
42			567202.4165	5472505.157
43			567180.4832	5472544.336
44			567170.3954	5472514.117
45			567153.5329	5472456.505
46			567135.938	5472400.843
47			567128.0923	5472385.297
48			567128.0861	5472385.285
49			567128.0456	5472385.195
50			567128.0345	5472385.168
51			567109.7557	5472338.458
52			567109.7389	5472338.413
53			567095.115	5472291.545
54			567075.5918	5472244.253
55			567075.5749	5472244.208
56			567059.8011	5472199.372
57			567044.8925	5472158.036
58			567044.2712	5472156.983

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, Хөдөө аж ахуйн байгууллага болон ГЗБГЗЗГ-ын хооронд хийгдсэн 2019/92 дугаартай гэрээнд заасан “Үндэсний хэмжээний газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлтийн үнэлгээ” хийх ажлын дагуу нийт 4232 цэгийг үнэлэх ажлыг 2020 оны 05 дугаар сарын 21-ний өдрөөс 08 дугаар сарын 31-ний өдөр хүртэл бүрэн үнэлж дуусган үр дүнг Суурь судалгаа мониторингийн хэлтсийн гэрээт ажилтан Д.Одончимэгт хүргүүлсэн болно.





Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст Дархан-Уул аймгийн төвийн Дархан сумын хот тосгон, бусад суурингийн газарт газрын төлөв байдал, чанарын улсын төлөвлөгөөт хянан баталгааг 2015 онд улсын төсвийн хөрөнгөөр Глобус ХХК хийсэн тухай албан бичиг болон хянан баталгааны загвар /Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны паспорт болон зураг/-ыг хавсралтаар хүргүүлсэн. Мөн

ГЗБГЗЗГ-ын Орон зайн мэдээлэл технологийн хэлтэст хүсэлт гаргаж Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан БНХАУ-ын ZY3 хиймэл дагуулын мэдээ авч ашиглах хүсэлтэй байгаа тухай албан хүсэлтийг эбел программаар гаргаж үүнийг дагуу 2018 оны 05 дугаар сарын 01-нд цуглуулсан боловсруулсан зургийг хүлээн авсан.



2020 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн газрын кадастрын мэдээллийн системийн http://192.168.15.216 цахим хаягийн гэрээний бүртгэлээс газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажил хийлгэх мэдэгдэх хуудас хэвлэгдэн гардаг болсон. Энэ ажлын хүрээнд нийт 96 иргэн, хуулийн этгээдэд газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажил хийлгэх тухай мэдэгдэх хуудсыг хэвлэж өгсөн.



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Дархан сумын Засаг даргын 2019-09-25- ний өдрийн А/214 дугаар захирамжаар 2020 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсэг байгуулан ажлын төлөвлөгөөг батлуулсан.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 18 багийн төв болон холбогдох байгууллагуудад ажиллаж газар зохион байгуулалтын төлөвлөгөөний талаар сургалт зохион байгууллаа.

Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журмыг холбогдох байгууллага /татварын хэлтэс, төрийн сангийн хэлтэс гэх мэт/ болон аймаг сумдын удирдлагууд, ИТХ түүний тэргүүлэгчид, газрын даамлуудад таниулах, хэрэгжилтийг хангаж ажиллах талаар танилцуулга хийж мэргэжил аргазүйн зөвөлгөө өгч албан тоот хүргүүсэн.

Засгийн газрын агентлагийн эрхзүйн байдлын тухай хуулийн 8-р зүйлийн 8,4 дэх хэсэг, газрын тухай хуулийн 23-р зүйлийн 2.8, 23.2.14 дэх заалт, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2020 оны 40-р тушаалаар батлагдсан “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журам” -ийн 1.2,

5.1, 11.1 дэх хэсгийг үндэслэн гаргасан тушаалын дагуу Дархан-Уул аймагт 2020.10.28-.29 -ны өдрүүдэд цахим систем нэвтрүүлэх сургалтийг Сэлэнгэ аймгийн 18 сумын даамал Дархан-Уул аймгийн 4 сумын даамал болон газар зохион байгуулалт, төлөвлөлт, газар өмчлөлийн асуудал хариуцсан мэргэжилтнгүүдийн дунд зохион байгуулж ажилласан

Газар зохион байгуулалт төлөвлөлтийн чиглэлээр :

Дархан-Уул аймгийн хэмжээнд 2020 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын хэсгийг сумын Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 25 -ны өдрийн А/214 дугаар захирамжаар байгуулсан бөгөөд уг захирамжийн дагуу ажлын ажлын хэсгийн уулзалтыг 2019 оны 11 дүгээр сарын 25 – ны өдөр зохион байгуулласан. Ажлын хэсгийн хурлаар 2020 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөөнд ирсэн саналыг аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнтэй уялдуулан хийж гүйцэтгэсэн.

Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд газрын харилцааны чиглэлээр 45, Барилга хот байгуулалтын чиглэлээр 4, нийт 49 багц ажлыг төлөвлөж хэрэгжүүллээ. Үүнд :

1. **Дархан сум** – Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2020.04.17-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор.
2. **Шарын гол сум** – Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2020.02.05 -ны өдрийн 09 дугаар тогтоол, 2020-06-27-ны өдрийн 27 дугаар тогтоол нэмэлт тодотгол оруулсан
3. **Орхон сум**- Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2019.12.11-ны өдрийн 19/09 дугаар тогтоолоор мөн 2020 оны сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 24 дугаар тогтоолоор тодотгол оруулсан.
4. **Хонгор сум** – Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2019.12.06-ны өдрийн 14 дугаар тогтоолоор тус тус газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг батлуулсан.


ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАРХАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг Газрын харилцаа, геодези, зураг, зүйн газрын даргын 2010 оны 11 дүгээр сарын 08 -ны өдрийн 497 дугаар аргачлалын дагуу төлөвлөгөөг боловсруулсан.

Уг арга зүйг баримтлан Дархан сумын 2020 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг газар ашиглах, эзэмшүүлэх, өмчлүүлэх, иргэд олон нийтийн оролцоо, тэдний санал дээр үндэслэн жилийн хугацаатай төлөвлөгөө хэрэгжүүлэх нөхцөл бүрдэж байгаа юм.

Аймгийн хэмжээнд тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт **82** хувь биелсэн байна.

Төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн хэмжээнд сум тус бүрээр нь харуулбал.

№	Сумын нэр	Төлөвлөгөөт ажил	Хэрэгжилт	Хувь
1	Дархан	49	45	91.8
2	Орхон	51	50	98
3	Хонгор	164	133	81
4	Шарын гол	37	19	51.4

2020 оны Дархан-Уул аймгийн Дархан суманд тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах ажлыг хийж гүйцэтгээд байна.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх

Дархан-Уул аймгийн хэмжээнд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэнээс хойших хугацаанд өмчлүүлсэн газрын судалгааг гаргаж, хуулийн

хугацаа дуусгавар болж байгаатай холбоотойгоор Дархан, Хонгор, Орхон, Шарын гол сумдад газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлэх, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцүүлэг, саналыг сумдын Засаг дарга, багийн засаг дарга нартай хамтран хэрэгжүүлж ажилсан.

“Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн нутаг дэвсгэрт 2003-2020 ондуудад нийт **14174** иргэнд **1564,69** га газрыг тус тус өмчлүүлсэн байна. Аймгийн хүн амын тоо харьцуулбал 13.4 хувьтай байна.



	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Дархан сум	204	2446	3362	3823	4022	4732	5330	5870	6582	7411	7842	7992	8259	8387	8485	8715	8788	8886
Орхон сум	8	85	468	530	535	546	564	604	681	977	1564	1837	2290	2458	2512	2784	2905	2905
Хонгор сум	77	174	408	435	438	448	468	530	559	585	758	805	923	1023	1071	1174	1207	1267
Шарын гол сум	11	59	313	372	421	460	513	730	781	855	931	945	975	992	1036	1079	1116	1116
Аймгийн хэмжээнд	300	2764	4551	5160	5416	6186	6875	7734	8603	9828	11095	11579	12447	12860	13104	13752	14016	14174

Аймгийн хэмжээнд газар өмчлүүлсэн байдал /2003-2020 он/

2020 онд “Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар иргэнд өмчлүүлэх газрын байршил, хэмжээг тогтоох тухай” аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 06 дугаар тогтоол батлагдан гарч аймгийн нутаг дэвсгэр дэх 28 байршилд иргэдэд гэр

бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулахаар шийдвэрлэсэн.

Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд шинээр 226 иргэнд 19,41 га газар, хуучин хашааны газарт 404 иргэнд 42,42 га газрыг өмчлүүлэхээр тусгуулан хэрэгжилтийг ханган ажилсан.

Тайлант хугацаанд буюу 2020 онд иргэнд газар өмчлүүлэх ажлыг аймгийн хэмжээнд сумдын Засаг даргын 12 удаагийн захирамжаар нийт 188 иргэн 18.43 га газар өмчлүүлсэн болно.

Газар өмчлөлийн хэрэгжилт

сумын нэр	**Төлөвлөсөн**				**Хэрэгжилт**				**Хувь**
	Шинээр		Хуучин сууршлийн бүсэд		Шинээр		Хуучин сууршлийн бүсэд		
	Иргэний тоо	Талбайн хэмжээ /га-аар/	Иргэний тоо	Талбайн хэмжээ /га-аар/	Иргэний тоо	Талбайн хэмжээ /га-аар/	Иргэний тоо	Талбайн хэмжээ /га-аар/	
Дархан сум			277	27,42			98	6.63	35.4
Шарын гол сум	10	0,7	37	3,20					
Хонгор сум	97	9,5	60	9,7			60	9,7	38.2
Орхон сум	119	9,21	30	2,1			30	2.1	100
Нийт	**226**	**19,41**	**404**	**42,42**			**188**	**18.43**	**46.6**

2020 онд шинээр өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай тогтоолын төслийг 2020 оны 3 дугаар сарын 18-ний өдрийн засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж шинээр газар өмчлүүлэхээр төлөвлөгдсөн байршил нь нийгмийн болон инженерийн дэд бүтэц, хөрөнгө оруулалтыг шийдсэн эсэх талаар тодруулах шаардлагатай гэсэн үндэслэлээр хойшлогдсон тул аймгийн хэмжээнд тус онд шинээр газар өмчлүүлэх ажил хэрэгжээгүй болно.

Хамтран өмчлөх эрхээсээ татгалзаж, дахин шинээр газар өмчлөх эрх үүсэх

Дархан-Уул аймгийн хэмжээнд хамтран өмчлөх эрхээсээ татгалзаж, шинээр газар өмчлөх эрхээ сэргээлгэхийг хүссэн иргэдийг сум бүрээр авч үзвэл Дархан сумд 125 иргэн, Хонгор сум 5 иргэн, Шарын гол 6 Орхон сум 5 иргэн сумын Засаг даргын 15 удаагийн захирамжаар нийт **141** иргэний асуудлыг шийдвэрлэсэн.

Өмчлөх эрхээ бусад аймаг, орон нутагт хэрэгжүүлэх

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд өөрчлөлт орсноос хойш аймгийн хэмжээнд газар өмчлөх эрхээ бусад аймаг, орон нутагт хэрэгжүүлэхээр хүсэлт гаргасан **10530** иргэнд лавлагаагаар үйлчилсэн ба тайлант онд 1750 иргэнд газар өмчилж аваагүй лавлагааг гаргаж өгч үйлчилсэн байна.

Газар өмчилж аваагүй лавлагаа авсан иргэд

Дээрх судалгаанаас харахад тайлант онд хамгийн их буюу 1750 иргэн лавлагаа авсан байгаа нь газар өмчлөлийн хуулийн хугацаа дуусгавар болж байгаатай холбоотойгоор иргэдийн газар авах сонирхол нэмэгдсэн байна.

Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем

Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системийг 2020 оны 03 дугаар сарын 02 -ны өдрөөс эхлэн нэвтрүүлэх тухай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын А/46 тушаал, “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журам батлах тухай” А/40 дүгээр тушаалыг тус тус гарсныг хавсралтаар холбогдох мэргэжлийн байгууллага болон аймаг, сумын Засаг дарга, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид, сумын Иргэдийн

Төлөөлөгчдийн хурлын дарга нарт, Аймгийн Ерөнхий архитекторт тус тус цахим системийг нэвтрүүлэх тухай албан бичгийг боловсруулж хүргүүлсэн.

“Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем” -д Дархан сумын 2020 оны төлөвлөгөөг нэгж талбар бүрээр нь оруулж, кадастрын давхцалыг арилгаж төслийг баталгаажуулж ажилласан. Төрийн байгууллагын зайлшгүй хэрэгцээ 5 нэгж талбар, дуудлага худалдааны 14 нэгж талбар, төсөл сонгон шалгаруулалтын 18 нэгж талбар, амины орон сууцны зориулалтаар 394 нэгж талбар, гэр бүлийн хэрэгцээний зориулалтай 277 нэгж талбар нийт 708 нэгж талбарыг цахим системд оруулсан.



Нэгж талбарыг цахим системд оруулсан байдал

Газар зохион байгуулалтын төлөвлөгөө сурталчлах талаар

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

2020 онд Дархан-Уул аймгийн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг сурталчлах ажлыг шинэлэг байдлаар pubhtml5 програм ашиглан хийж, байгууллагын цахим хуудас болон фэйс бүүк хуудсаар сурталчлах ажлыг ил тод нээлттэй явуулж байгааг иргэдийн зүгээс сайшаан дэмжиж байлаа. Мөн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг албан байранд зурагт хуудас, ТВ-ээр, “ Нээлттэй хаалга”-ны өдөрлөгөөр, орон нутгийн ТВ болох Лха, А Жи Би, Ди Би Эс ТВ-ээр тус тус сурталчилан ажилсан.



Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг иргэдэд сурталчилсан

Дархан-Уул аймгийн 2021 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд санал авах ажил

Дархан-Уул аймгийн 2021 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний санал авах ажлыг 8 дугаар сараас эхлүүлж шинэлэг байдлаар www.darkhan.gazar.gov.mn цахим програм ашиглан байгууллагын цахим болон фэйс бүүк хуудсанд санал авах ажлыг зохион байгууллаа.





Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд санал авч буй байдал

Дархан сумын Засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 31 -ний өдрийн А/133 дугаар захирамжаар 2021 оны Дархан сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг томилогдсон. Уг ажлын хүрээнд ажлын төлөвлөгөөний дагуу Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.1 заалтын дагуу Дархан сумын 2021 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал өгөх тухай аймаг, сумын Засаг дарга нар, Инженерийн шугам сүлжээний байгууллага болон төрийн байгууллагууд албан бичиг хүргүүлсэн. Дархан сумын багийн Засаг дарга нартай батлагдсан хуваарийн дагуу Дархан сумын 1-15 баг, Өргөө, Малчин багийн төвүүд дээр очиж 2021 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал авах талаар хамтран ажилсан.

Багийн төвүүдээр ажиллаж төлөвлөгөөний санал авах ажлын заавар өгч буй нь

2021 оны төлөвлөгөөнд тусгах санал авч ажилсан байдал

2021 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийт 228 санал ирүүлснээс ААНБ 9, иргэн 219 санал хүргүүлснийг хүлээн авч нэгтгэн Газар зохион байгуулалт, хот байгуулалтын цахим системд төслийг үүсгэн ажиллаж байна.

КАДАСТР

Кадастр, бүртгэлийн ажлын талаар

Иргэн, хуулийн этгээдийн өргөдөл хүсэлтийг https://egazar.gov.mn/, е газар гар утасны апплейкшн ашиглан цахим системээр дамжуулан хүлээж авах программ хангамж нь хөгжүүлэлтийн шатандаа явж байна.

Газар эзэмших, өмчлөх 1158 иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, хүсэлтийг шийдвэрлээд байна. Үүнээс:

- Өмчилсөн газраа шийлжүүлэх-671
- Газар эзэмших эрхийн хугацаа сунгах, бусдад шилжүүлэх,зориулалт өөрчлүүлэх гэрээ, гэрчилгээг шинэчлүүлэх тухай-219
- Газрын маргаан шийдвэрлүүлэх тухай-2
- Шинээр газар эзэмших-57
- Цагдаа болон шүүх, банкны лавлагаа-18
- Өмчилсөн газрын талбайн хэмжээний зөрүү арилгасан-68
- Бусад-123

Улсын Бүртгэлд 259 нэгж талбар илгээж дугаар олгоод байна.

Газар эзэмших, ашиглах, өмчлөх газартай иргэн, хуулийн этгээдэд 1926 кадастрын зураг хэвлэж өгсөн байна.

- Өмчлөх-687

- Өмчилсөн газраа худалдах, бэлэглэж, өвлөн шийлжүүлсэн-583
- Өмчилсөн газраа хуваасан-88

Эзэмших, ашиглах-568

Мэдээллийн санд бүртгэгдээгүй 286 иргэн, хуулийн этгээдийг газрыг нөхөн бүрдүүлж цахимжуулсан.



Иргэн, хуулийн этгээдийн газар өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой 1158 өргөдөл, хүсэлтийг бүртгэж, шийдвэрлэжээд байна.

Улсын Бүртгэлд 259 нэгж талбар илгээж дугаар олгоод байна.



Газар эзэмших, ашиглах эрх олгогдсон **268** иргэн хуулийн этгээдэд гэрчилгээ бичиж өгсөн. Газар эзэмших, ашиглах, өмчлөх газартай иргэн, хуулийн этгээдэд **1926** кадастрын зураг хэвлэж, давхардсан тоогоор **5926** ширхэг кадастрын үнэт цаас зарцуулаад байна.





Тусгай захиалгат ажлын талаар

2020 онд Дархан-Уул аймагт иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай, 2019 оны Газрын нэгдмэл сангийн тайланг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн 2020 оны 07 дугаар тогтоолоор баталуулсан

Нийт газар нутгийг газар ашиглалтын зориулалтыг нь тулгах засварлах ажил хийгдэж байна. Үүний хүрээнд

• Дархан суманд 601 өмчлөх, эзэмших, ашиглах эрхтэй нэгж талбар

• Орхон суманд 33 өмчлөх, эзэмших, ашиглах эрхтэй нэгж талбар

• Шарын гол суманд 20 өмчлөх, эзэмших, ашиглах эрхтэй нэгж талбар

• Хонгор сумын 100 эзэмших, ашиглах эрхтэй нэгж талбаруудыг засварлаад байна.

- Мэдээллийн санд байгаа газар ашиглалтын зориулалт ороогүй 208 нэгж талбаруудыг зориулалтыг оруулсан.

- Газрын төлбөр хураалт татварын алба руу шилжиж байгаатай холбогдуулан газрын кадастрын мэдээллийн санд байгаа газар эзэмших гэрээ нь эзэмшигч иргэн, хуулийн этгээдийнхээ мэдээлэлтэй зөрүүтэй байсан 376 гэрээг засварласан. Мөн үл хөдлөх хөрөнгийн албан татварын ногдуулалтыг манай байгууллага хийж байгаатай холбогдуулан газрын кадастрын мэдээллийн санд газар ашиглалтын зориулалт тодорхойлогдоогүй байсан 546 нэгж талбарыг засварласан.

Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчилсөн 1311 нэгж талбар бүртгэхээс 289 нэгж талбарыг бүртгэсэн ба 934 нэгж талбарын мэдээллийг цуглуулж ЛМ-д оруулахад

бэлдээд байна.

Эзэмших, ашиглах эрхтэй 1498 нэгж талбарыг мэдээллийн санд нөхөн бүрдүүлж оруулуулахаас 625 нэгж талбарыг мэдээллийн санд нөхөн бүрдүүлж оруулсан байна. Үлдсэн мэдээллийг мэдээллийн санд оруулахаар мэдээллийг цуглуулж байна.

Нийт 2809 нэгж талбараас өмчлөх эзэмших, ашиглах 914 засварлаж, өмчлөх 934 нэгж талбар мэдээллийн санд оруулахад бэлэн болгож, өмчлөх 88 нэгж талбар, эзэмших, ашиглах 873 нэгж талбар үүсгэх дутуу байна. Мөн газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх зүйн харилцаа үүссэн 1423 нэгж талбар бүртгэгдсэн байна.

Дархан сум, Орхон сумын хил дамнасан нэгж талбар буюу хөтөл хорооллыг 60 хашаа байна. Энэ хэсэгт орсон хашаа нь УИХ-ын тогтоолоор батлагдсан хилийн цэстэй давхардаж байгаа нь тогтоолоо өөрчлөх болж байгаа тул боломжгүй байна. Хонгор сумын 1-р баг Цогт хэсгийн нэгж талбар буюу хашаа-84 тус тус нэгж талбаруудыг харъяалах нутаг дэвсгэрт иргэний хаягийг шилжүүлэхгүйгээр үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэхээр төлөвлөсөн. Хүсэлт ирүүлсэн 27 иргэний өмчлүүлсэн газрын хаяг, талбайн хэмжээ өөрчлөж Аймгийн Засаг даргын 2020 оны 01-А/332 дугаар захирамж гаргуулж, Улсын бүртгэлийн хэлтэсд 2020 оны 978 албан бичгээр хүргүүлсэн. Үлдсэн иргэдтэй уулзалт зохион байгуулсан боловч одоог хүртэл хүсэлт ирүүлэхгүй байна.

Зураг зүйн ажлын талаар

Цагдаа, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, авилгатай тэмцэх газарт 23 шинжээчийн дүгнэлт, нотлох баримт, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад лавлагаа, мэдээллийг гаргаж хүргүүлсэн.

Ветмон ХХК-д Дархан-Уул аймгийн Дархан сумын 3-р баг, Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 3-р баг, Ширээнуруунаас Хавцал хүртлэх агаар сансарын зурийг албан хэрэгцээнд зориулж гаргаж өгөв.

Дархан-Уул аймгийн Цагдаагийн газарт Дархан сумын 18 багийн хилийн цэсийг харуулсан зургийг албан хэрэгцээнд зориулж файлаар өгөв.



Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт Дархан-Уул аймгийн хэмжээнд байгаа оршууллагын газрын судалгааг гаргаж shape файлаар хүргүүлсэн.

Газрын төлбрийн хууль өөрчлөгдсөнтэй холбогдуулан уурхайн газарт төлбөр бодох аргачлалын дагуу Дархан-Уул аймгийн сумды нутаг дэвсгэр дэх бүчлэлийн зургийг гаргав.



Дархан нэхий ХК-ны эзэмшил газраар “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн 17.14 дах, Барилгын тухай хууль”-ийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дах заалтуудыг зөрчиж байгаа 4505701666 нэгж талбарын дугаартай 3861м2 газраас 1052 м2, 4505701667 нэгж талбарын дугаартай 5431м2 газраас 343 м2 газрын тус тус хасах шаардлагтай байгааг үүгээр мэдэгдэж зураг хийж албан тоот хүргүүлсэн.

Дархан-Уул аймгийн Цагдаагийн газарт ухагдсан газрын 4 зураг гаргаж өгөв.





Дархан-Уул аймгийн Хонгор сумын 3-р баг Салхит баг хүртлэх хатуу хучилттай авто замын зурвасын төслийн зурагтай танилцаж зураг төслийг гүйцэтгэгч Мөнхийн тод зам ХХК-д чиглэл өгсөн.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын ундны усны нөөц газар Мон рок ХХК-ны ашигт малтмал олборлох ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, Заамар гоулд ХХК нь ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшдэг талбайтай нь тавхардаж байгаа талаар аймгийн ИТХ-ын Байгаль орчин, экологийн бодлого хяналтын хорооны Төлөөлөгчидөд танилцуулга хийж, зураг гаргаж өгөв.



Дархан-Уул аймгийн Цагдаагийн газрын Экологийн асуудал хариуцсан байцаагч, дэслэгч Э.Бат-Очир, Б.Отгонсүрэн нараас 2020-04-14-ний 9, 11 дугаартай шинжээч томилж шинжилгээ хийлгэх тухай тогтоолын Дархан-Уул аймгийн Хонгор сумын 1-р багийн нутаг дэвсгэрт түгээмэл дархацтай ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөлтэй MV-017041 дугаартай талбайд олборлолт хийсэн гэх “Мөнхболор эрдэнэ ХХК

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “Цогт толгой хойд толгой” гэх талбайд хуучин ашиглаж байсан талбайгаас түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан “Өсөх-Урам”ХХК нарт холбогдох тайлбар хүргүүлж зураглал үйлдсэн.



Дархан-Уул аймгийн Цагдаагийн газрын Мөндөн байцаах тасагт шалгагдаж байгаа 472 дугаартай гомдлын дагуу ирүүлсэн солбицолын дагуу Дархан-Уул аймгийн Шарын гол сум, Сэлэнгэ аймаг, Баянгол сумын хилийн заагт 19810 м2 газрын зураглал гаргаж өгөв.



Дархан-Уул аймгийн Цагдаагийн газарт шалгагдаж байгаа 5 иргэн, хуулийн этгээдийн талаарх ашигт малтмал олборлосон газрын талаархи мэдээллийг 2020 оны 194, 245, 247,551 албан бичгээр хүргүүлсэн.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт түгээмэл дархацтай ашигт малтмал олборлосон гэх "Эйч Эйч Жи" ХХК



Дархан-Уул аймгийн Хонгор сумын 2-р багийн нутаг дэвсгэрт Хүйтний голд MV-014989 дугаартай ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөлтөй газарт зөвшөөрөлтэй газраасаа илүү гаргаж олборлолт явуулсан гэх Бичигт хад майнинг ХХК,



Дархан-Уул аймгийн Хонгор сумын 2-р багийн нутаг дэвсгэрт ашигт малтмал олборлосон Хааны харгуй ХХК, Дархан-Уул аймгийн Хонгор сумын 2-р багийн нутаг дэвсгэрт ашигт малтмал олборлосон Очир-Ундраа ХХК,

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 2-р багийн нутаг дэвсгэрт ашигт малтмал олборлосон Шенг чанг ХХК зэрэг хуулийн этгээдийн талаар шинжээчийн дүгнэлтийг Дархан-Уул аймаг дахь Цагдаагийн газарт 2020 оны 320, 321, 543, 860 албан бичгээр хүргүүлсэн.



Сургалт, зөвлөмжийн талаар

2020-03-05-ны өдөр сумдын даамал нарт Лэнд менежерийн вэб хувилбарын сургалтыг зохион байгуулсан. Тухайн сургалтаар захирамж оруулах, уурхайн зориулалттай газрын төлбөр бодуулах, уурхайн газрын зориулалт бүрээр хэрхэн sub_parcel давхаргад зураглах.

2020-06-13 өдөр сумдын даамал нарт шилэн кабелийг Лэнд менежер программд оруулж parcel_line давхаргад шулуун хэрхэн зурж төлбөр бодуулах талаар сургалтыг зохион байгууллаа.



2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр, 5 дугаар сарын 12 -ны өдрүүдэд Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газраас зохион байгуулсан “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем” -ийг 2020 оны 03 дугаар сарын 02 -ны өдрөөс эхлэн улсын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлэх видео сургалтанд 4 сумын газрын даамал, кадастрын мэргэжилтэн, хот байгуулалтын кадастрын мэргэжилтэн, Газрын удирдлагын хэлтсийн дарга, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн нийт 8 хүн хамрагдсан.

Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системийн сургалтыг ГЗБГЗЗГ-ын ГЗБ-ын хэлтэсээс 2020 оны 10 дугаар сарын 28, 29 өдрүүдэд хамрагдсан.





Газрын төлбөр, татварын чиглэлээр Засгийн газрын тогтоол болон бусад дүрэм журамд санал өгөх, тайлан мэдээ гаргаж хүргүүлсэн байдал:

№	Тайлангийн нэр	Хүргүүлэх хугацаа	Хүргүүлсэн огноо	Ямар хэлбэрээр хэзээ, хаана хүргүүлсэн, хэрэгжсэн	Тайлбар
1	Газрын төлбөрийн ТТ-20 тайлан	2020.02.20	2020.02.11	Аймгийн Татварын цахим системд тоон гарын үсгээр илгээсэн.	ТТ-20 тайланг Татварын хэлтсээс 3 удаа засварлуулсан. Учир нь 2019 оны газрын төлбөрийн дутуу орлогыг ГХБХБГ аймгийн төсөвт төвлөрүүлэх болсон тул өмнөх оны газрын төлбөрийн дутуу өр 481.4 сая төгрөгийн судалгаа мэдээллийг шалган хүлээн авч, засварласан.
2	ГЗБГЗЗГ, Татварын ерөнхтй газрын даргын 2020.10.20-ний өдрийн 01/04 албан даалгавар гүйцэтгэл	2020.11.09	2020.11.09	Цахим хаягаар болон шуудангаар ГЗБГЗЗГ, ТЕГ-т тус тус хүргүүлсэн	ГЗБГЗЗГ-т bayantumen.p@gazar.gov.mn, Татвар хураалтын удирдлага, арга зүйн газарт munkhnasan.b@mta.gov.mn тус тус хүргүүлсэн.
3	ГЗБГЗЗГ-ын 2020.01.09-ны өдрийн А/05 дугаар тушаалын дагуу Газрын төлбөр, татварын системийг нэвтрүүлэх	2020.01.09	2020.02.07	Цахим системийн хөгжүүлэлттэй холбоотой улсын хэмжээнд 2020.02.07-ны өдрөөс нэгэн зэрэг нэвтэрсэн.	Татварын цахим системд Газрын төлбөрийн ногдуулалтыг үүсгэх ажлын хүрээнд Дархан-Уул аймаг цахим системд шилжсэн 5 дахь аймаг болсон.
4	Газрын төлбөрийн нэхэмжлэл үүсгэсэн судалгааг аймгийн Татварын хэлтэст хүргүүлэх	Улирал бүр	2020.03.31, 2020.06.30, 2020.09.07	2020.11.04, 2020.12.04 Цахим хаягаар илгээсэн	bayartsetseg.b@da.mta.gov.mn , darkhan@mta.gov.mn
5	Засгийн газрын 2016 оны 10-р тогтоолоор батлагдсан Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журамд нэмэлт өөрчлөлт оруулах	2-р улирал	2020.03.05, 2020.03.27	ГЗБГЗЗГ-аас зохион байгуулсан цахим хурлаар 21 аймгийн төлбөрийн мэргэжилтнүүд санал солилцсон.	Монгол Улсын Засгийн газрын 2020.04.29-ний өдрийн 152 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон.
6	Газрын төлбөр, татвартай холбоотой мэдээллийг цахим, бусад хэлбэрээр харилцан солилцох журамд санал өгөх	2020.02.20	2020.02.17	Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар, Татварын ерөнхий газрын хооронд мэдээлэл солилцох журмын төсөлтэй танилцаж 2020.02.17-ний өдрийн 127 тоот албан бичгээр санал хүргүүлсэн.	Барилга, хот байгуулалтын сайд, Сангийн сайдын хамтарсан 2020.09.11-ний өдрийн 173/178 дугаар тушаалаар “татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хоорондын мэдээлэл солилцох журам” батлагдсан.
7	Газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээллийг цуглуулах заавар, маягтыг шинэчлэн боловсруулах	2-р улирал	2020.03.05, 2020.03.27	ГЗБГЗЗГ-аас зохион байгуулсан цахим хурлаар 21 аймгийн төлбөрийн мэргэжилтнүүд санал солилцсон.	Газрын цахим биржийн системд үнийн мэдээ цуглуулах маягтад тухайн газар дээрх барилгын мэдээлэлтэй холбоотой мэдээллийн шинэчлэлт хийгдсэн.

Газрын төлбөр, татварын цахим систем нэвтрүүлсэн байдал:

ГЗБГЗЗГ-ын 2020.01.09-ны өдрийн А/05 дугаар тушаалын дагуу Газрын төлбөр,татварын цахим систем амжилттай нэвтэрсэн. Улсын хэмжээнд 2020.02.07-ны өдрөөс эхлэн газрын төлбөр цахимаар нэхэмжлэл үүсэж эхэлсэн бөгөөд Дархан-Уул аймаг цахимд шилжсэн 5 дахь аймаг болсон.

№	Сумын нэр	Цахим системд шилжүүлэх гэрээний тоо, мөнгөн дүн Төлөвлөсөн /2019.12.31/		Цахимд шилжсэн гэрээний тоо, мөнгөн дүн, нэхэмжлэлийн тоо Хэрэгжсэн /2020.12.22/		
		Гэрээний тоо	Мөнгөн дүн /сая.төг/	Гэрээний тоо	Нэх.үүссэн мөнгөн дүн /төгрөгөөр/	НЭХ.тоо
1	Дархан сум	2729	805.1	2983	1036356974	9709
2	Орхон сум	289	30.1	467	22818231	1033
3	Хонгор сум	1023	268.5	1471	266306430	4676
4	Шарын гол сум	220	101.7	239	98682850	636
Аймгийн хэмжээнд		4261	1205.4	5160	1424164485	16054
Гүйцэтгэлийн хувь				121%	118%	

2020 оны газрын төлбөрийн нэхэмжлэлийг цахим системд үүсгэсэн байдал, 2020 оны газрын төлбөрийн орлого, гүйцэтгэлийг сум тус бүрээр үзүүлбэл:

№	Сумын нэр	Нэхэмжлэл үүсгэх гэрээний тоо		Нэхэмжлэл үүсгэсэн Мөнгөн дүн /төгрөгөөр/	40:60	Төлсөн	Нийт
Дархан сумын 6-р баг 19-р хороололд ХЕТ-ний дагуу дахин төлөвлөлтийн хүрээнд 60 айлын 1 Орон сууц баригдаж ашиглалтад орсон. Мөн энэ онд 60 айлын 1 орон сууцны барилгын ажил хийгдэж байна.

Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийгдсэн байршилуудад барилгажилт зөвхөн төлөвлөлтийн дагуу явагдаж байна, барилгажсан хорооллын дунд нягтруулж барилгажуулахад хот байгуулалтын шаардлага норм дүрмийн дагуу шийдвэрлэдэг бөгөөд ноцтой зөрчил гараагүй болно.

Дархан сумын 31-р хороолол 425 айл, 25-р хороолол 251 айл, Шарын гол сумын төвийн хэсгийн ХЕТ-ний дагуу 110 айлын амины орон сууцны газрыг төлөвлөлтийн дагуу олгосон байна.



Аймаг, хотын Ерөнхий архитекторын үйл ажиллагаа

Аймгийн ерөнхий архитектор Д.Элдэвсайхан 2019 оны тайлангаа дүрмийн дагуу гаргаж хугацаанд нь хүргүүлсэн бөгөөд 87,6% -аар үнэлэгдсэн.

2020 онд хот байгуулалтын чиглэлээр төлөвлөгдсөн ажлууд 90 гаруй хувиар биелсэн байна. Энэ талаар 2020 оны Засаг Даргын тайланд тусгагдсан. Мөн мэргэжилийн хяналтын газрын төлөвлөгөөт хяналт шалгалтанд хамрагдаж хангалттай гэсэн үнэлгээ авсан.

Дархан-Уул аймгийн хэмжээнд барилгын норм, дүрэм, журмыг үндэслэн иргэн, АА-д 95 архитектур төлөвлөлтийн даалгавар төлөвлөн баталгаажуулалт хийж ажилласан.

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаа

2020 онд батлагдсан Дархан хотын шинэ Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу тус хотод урт хугацаанд дахин төлөвлөлт хийх бодлогыг тодорхойлж хамрах хүрээ, зориулалт байршлыг тогтоон Аймгийн ИТХТ-н 2020 оны 68 тоот тогтоолыг гаргуулсан.

Энэ тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Дахин төлөвлөлтийн төлөвлөгөөний төсөл боловсруулаад байна.

Дахин төлөвлөлтөнд хамрагдмах 19-р хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хийлгэж батлуулсан.

Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу 19-р хороололд 60 айлын 1 барилга баригдаж дууссан. 2020 онд эхэлсэн 60 айлын орон сууцны 2 дах барилга 50%-н гүйцэтгэлтэй явагдаж байна. Уг орон сууцны төсөвт өртөг болох 3 тэрбум төгрөгийг Орон нутгийн төсөв суулгасан.

Дахин төлөвлөлтөнд хамрагдах байршилуудад 2019-2021 он хүртэл хийгдэж байгаа инженерийн төв шугам сүлжээний ажил 86%-н гүйцэтгэлтэй явагдаж байна. / Нийт төсөвт өртөг нь 17,3 тэрбум төгрөг /





ХОТ БАЙГУУЛАЛТЫН КАДАСТР

Хот байгуулалтын кадастр болон архивын санг бүрдүүлэлт

Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагааг хэвийн явуулахын тулд иж бүрэн компьютер 1 ширхэгийг бэлтгэн ажиллаж эхэлсэн. Тус компьютерын үзүүлэлт Windows 10 pro үйлдлийн системтэй, Core i7-9700, 8gb ram

Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн дотоод хяналт шинжилгээг улирал тутамд үнэлгээ хийж Хот байгуулалтын кадастрын хэлтэсд хүргүүлсэн.

1-р улирлын дотоод хяналт шинжилгээний үнэлгээг 700 барилга байгууламжийн мэдээллээс 70 барилга байгууламжийн мэдээллийг түүвэрлэн 80%

2-р улирлын дотоод хяналт шинжилгээний үнэлгээг 730 барилга байгууламжийн мэдээллээс 21 барилга байгууламжийн мэдээллийг түүвэрлэн 89%

3-р улирлын дотоод хяналт шинжилгээний үнэлгээг 766 барилга байгууламжийн мэдээллээс 91 барилга байгууламжийн мэдээллийг түүвэрлэн 91% үнэлгээгээр дүгнэгдэж хүргүүлсэн.

Мэдээлэл бүртгэх сайт



Ногоон байгууламж

Улсын хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд Дархан суманд баригдсан барилга байгууламжуудын мэдээллийг бүрдүүлж 98%, Дархан сумын инженерийн төв магистрал шугамын мэдээллийг 93%, тохижилт ногоон байгууламжийн мэдээллийг 85% оруулаад байна. Мэдээлэл оруулах цахим сайт www.urban.gov.mn.





2019 оны ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлтийн тайланг 2020.02.15 өдөр ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. Тайланд 2019 онд баригдаж ашиглалтанд орсон нийт 21 барилга, 5 инженерийн шугам сүлжээний мэдээллийг хүснэгтэн мэдээлэл, бичмэл тайлан, ArcGis програмд ship файлаар оруулж хүргүүлсэн.

ГЗБГЗЗГ-аас зохион байгуулж буй хот байгуулалтын мэдээллийн санд сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний мэдээлэл оруулах 21 аймгийн тэмцээнд оролцож Дархан-Уул аймгийн Шарын гол сум, Өвөрхангай аймгийн Гучин ус сум, Сэлэнгэ аймгийн Ерөө сумдын ерөнхий төлөвлөгөөг мэдээллийн санд оруулсан.





ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГА

Салбар болон байгууллагын урт, богино, дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулахад санал өгсөн байх, батлуулсан байх, холбогдох хууль тогтоомж болон тэдгээрт нийцүүлэн гарах хэм хэмжээний акт, бусад баримт бичгийг боловсруулж , батлуулах ажлыг зохион байгуулсан байна

1. Байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд 2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулсан.
2. Байгууллагын зөвлөгөөн, сургалтын 2020 оны төлөвлөгөөг батлуулсан
3. Байгууллагын “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах” чиглэлээр зохион байуулах үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөөг батлуулсан
4. Байгууллагын “Гэр бүлийн хөгжил”-ийг дэмжих 2020 оны төлөвлөгөөг батлуулсан.
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо хөгжлийг дэмжих чиглэлээр салбарын хэмжээнд зохион байгуулах ажлын 2020 оны төлөвлөгөөг батлуулсан.
6. Байгууллагын хянлт-шинжилгээ үнэлгээний багийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан.
7. Газрын удирдлагын хэлтсийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуусан.
8. Барилга хот байгуулалтын хэлтсийн 2020 оны ажлын төлөвлөгөөг батлуулсан.

9. “Хариуцлагатай-хэрэгжлэгч” арга хэмжээний төлөвлөгөөг батлуулсан.
10. “Ёс зүйн зөвлөл”-ийн үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөөг батлуулсан

Байгууллагын 2020 оны зөвлөгөөн, сургалтын төлөвлөгөөг газрын даргаар батлуулж, хагас жилийн хэрэгжилтийн тайланг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.

Байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 2020 оны төлөвлөгөөг батлуулж, хагас жилийн хэрэгжилтийн тайланг гаргаж ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.

Байгууллагын “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах” чиглэлээр зохион байгуулагдах 2020 оны төлөвлөгөөг боловсруулж газрын даргаар батлуулж хагас жилийн хэрэгжилтийн тайланг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, хагас жилийн хэрэгжилтийн тайланг ГЗБГЗЗГ-т gantsetsegsuren@yahoo.com цахим хаягаар нэгтгэж хүргүүллээ.

Удирдлагын академийг ГХБХБГ-ын дарга болон кадастрын мэргэжилтэн нар төгссөн. Энэ жилийн төлөвлөгөөний дагуу удирдлагын академид БХБХ-ийн Инженерийн шугам сүлжээ хариуцсан мэргэжилтэн болон ГУХэлтсийн Суурь судалгаа, мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн суралцуулаж байна.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт хэрэгжүүлэх “хариуцлагатай-хэрэглэгч” арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийн тайланг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.

Газрын харилцаа, барилга, хот байгуулаллтын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний багийн 2020 онд хийх ажлын төлөвлөгөөг батлуулж, нийт албан хаагчдын нэгдүгээр улирал, хагас жилийн гүйцэтгэлийн тайлан, хөдөлмөрийн гэрээний тайланг дүгнэсэн.

Дархан-уул аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын иргэний болон захиргааны хэргийн анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхээр шийдвэрлэгдсэн 2019 оны хэргийн жагсаалтыг гаргав.

Байгууллагын даргын 2020.03.11-ний өдрийн А/10 тоот тушаалаар аймгийн Засаг даргын захирамжыг хэрэгжүүлж, байгууллагын албан хаагч болон иргэдийг халдварт

өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “хариуцлагатай жижүүрийн ажиллах хуваарь”-ийг батлан мөрдүүлж байна.

Байгууллагын даргын 2020.03.03-ны өдрийн А/09 тоот тушаалаар “Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хугацааг сунгах” шийдвэр гарч ажлын цагийн хуваарийг батлав.

Аймгийн ЗДТГ-ын Захираа удирдлагын хэлтэсд албан хаагчдын зэрэг дэвийн шаардлага хангасан ахлах түшмэлийн албан тушаалд-1, дэс түшмэлийн албан тушаалд-4 албан хаагчдын материалыг хүргүүлж, аймгийн Засаг даргын Зэрэг дэвтэй холбоотой захирамж гарсан.

Бүтцийн өөрчлөлтөөр 23 албан хаагчийн орон тоогоор батлагдсан, 2 хэлтэс нь нэг нэг алхахтай болсон, 2 ахлах мэргэжилтэн журмын дагуу томилогдсон, Бичиг хэрэг, архив, нярав хариуцсан мэргэжилтэн ангилал нь өөрчлөгдөн Төрийн захиргааны албан хаагч болсон, төрийн албаны тусгай шалгалтыг зарлах хүртэл өмнөх ажилтнаа түр томилсон. Барилга хот байгуулалтын хэлтэст шинэ орон тоо болох Хот байгуулалтын кадастр, зураг төсөл магадлал хариуцсан мэргэжилтний орон тоог ТАСЗөвлөлд зарлуулхаар хүргүүлсэн ч одоогоор сонгон шалгаруулалтыг Улс орон даяар онцгой байдал зарласантай холбогдуулан хойшилсон. Агентлагт хүний нөөцийн мэдээллийг шинэчлэн хүргүүлсэн, төрийн албаны хүний нөөцийн системд албан хаагчдын мэдээллийг тухай бүрт нь өөрчлөлтийг оруулж ажиллаа. 4 аблан хаагч хүүхэд асрах чөлөөтэй, 2 албан хаагч өөрийн хүсэлтээрээ чөлөөлөгдсөн. Шарын гол, Дархан сумын даамлын орон тоонд түр хугацаанд 2 мэргэжилтэнг томилон ажиллуулж байна. МУЗГ, аймгий ЗДЗахирамжын дагуу ГХБХБГДаргын тушаалаар албан хаагчдын ажлын цагийг тусгай горимын дагуу богиносон ажиллаж байна.

2019, 2020 оны 1-р улиралын байдлаар ёс зүйн зөрчил, болон ашиг сонирхлыг зөрчилгүй ажиллаа. Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинээр баталсан. Нийт 5 гишүүнтэй, ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуул, мөрдүүлж ажиллаа.

Монгол Улсын төрийн болон албаны нууцын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-ын 4.3.1 заалтын үндэслэн төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтэнийг баталсан ГХБХБГ-ын даргын тушаал, тэдгээрийн нууцтай танилцах эрхийн түвшинг тогтоосон материлыг Тагнуулын газарт хүргүүлэв.

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлыг 2020 онд 4 удаа зохион байгуулж байгууллагат худалдан авах тоног төхөөрөмж сэлбэг хэрэгсэлийг хэлэлцүүлэн шийдвэрлэв. Мөн актлах бараа материалыг устгалд оруулах ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

ГЗБГЗЗГ-ын даргын тушаал гаргаж дараах журмуудыг шинэчлэн боловсруулж байна.

- “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох” журамыг шинэчлэн боловсруулах тухай 2020-06-03 3/1676 тоот албан бичиг
- “Газрын кадастрын мэдээллийн санг ажиллуулах” журам шинэчлэн боловсруулах тухай 2020-05-18 2/1454 тоот албан бичиг
- “Иргэнд газар өмчлүүлж, кадастр хийх” журам шинэчлэн боловсруулах тухай 2020-05-28 2/1454 тоот албан бичгээр ирүүлсэн тушаал бүрийг хяналтанд авч хариуг албан тоотоор хүргүүлсэн.
- “Газар зохион байгуулалт хийх журам”-ыг шинэчлэн боловсруулах 2020-11-11 өдрийн 1/3232 дугаартай албан бичгээр ирүүлсэн журамтай танилцсан саналгүй гэсэн хариуг өгсөн.
- “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох” журамыг шинэчлэн боловсруулах тухай 2020-06-03 3/1676 тоот албан бичиг
- “Газрын кадастрын мэдээллийн санг ажиллуулах” журам шинэчлэн боловсруулах тухай 2020-05-18 2/1454 тоот албан бичиг
- “Иргэнд газар өмчлүүлж, кадастр хийх” журам шинэчлэн боловсруулах тухай 2020-05-28 2/1454 тоот албан бичгээр ирүүлсэн тушаал бүрийг хяналтанд авч хариуг албан тоотоор хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын тогтоол гарч дараа тогтоолуудын хяналтандаа авч хэрэгжилтиийг хангаж ажиллаж байна.

- Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэхтухай Засгийн газрын 2020-03-25 110 тогтоол,
- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагуудыг тоолууржуулах тухай Засгийн газрын 2020-04-22 144 тогтоолуудын хэрэгжилтийг гарган хүргүүлсэн.

АТГ-д 5 иргэнтэй холбоотой хэрэг үүсгэн шалгагдаж байгаа тул нотлох баримтыг гаргаж 2020 оны 469 албан бичгээр лавлагааг хүргүүлсэн.

ДУА Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхээс 3 нотлох баримт гаргуулахаар хүсэлт ирүүлснийг 2020 оны 293, 347, 417 албан бичгээр лавлагааг хүргүүлсэн.

ЭБАТ-ын чиглэлээр

Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдэгдлийг 2020 оны 12 сарын 10-ны өдрийн байдлаар 146 мэдэгдлийг албан хаагчид гаргаж, АТГ-ын мэдүүлэг бүрдүүлэлтийн программд шивэж оруулсан.



Мөн 4 албан тушаалтны ХАСХОМ-ийн 2020.02.14-2020.02.18-ны өдрүүдэд хүлээн авч АТГ-ын цахим бүрдүүлэлтийн системд бүртгэн баталгаажуулж, 2019 оны ХАСХОМ-ын тайлангуудыг гаргаж аймгийн Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Энхсайханд 2020.02.20-ны өдрийн 141 тоот албан бичгээр хүлээлгэж өгсөн.

Байгууллагын нийтийн албан тушаалтанд зориулсан сургалтанд хамрагдах албан хаагчдын нэрсийг Авлигатай тэмцэх газрын www.iaac.mn цахим хуудсанд бүртгэж, аймгийн Хууль, эрх зүйн хэлтэст 2020.03.18-ны өдрийн 235 тоот албан бичгээр хүргүүлсэн.



АТГ-ын цахим хуудсанд нийтийн албан тушаалтанд зориулсан сургалтанд бүртгэсэн байдал

Байгууллагын 2020 оны авлигатай тэмцэх, шударга ёс, ил тод байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийн боловсруулж газрын даргаар 2020.03.16-ны өдөр батлуулсан. Мөн аймгийн Хууль, эрх зүйн хэлтэст байгууллагын 2020 оны эхний хагас жилийн авлигатай тэмцэх, шударга ёс, ил тод байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2020.06.16-ны өдрийн 612 тоот, ГЗБГЗЗГ-т 613 тоот албан бичгээр, мөн бүтэн жилийн тайланг аймгийн Хууль эрх, зүйн хэлтэст 2020.12.11-ний өдөр 1023 тоот, ГЗБГЗЗГ-т 1024 тоотоор тус тус хүргүүлсэн.



ДАРХАН-УУЛ АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

2020.12.11 № 1023
танай ____-ны № ____-т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭСТ

Тус байгууллагын 2020 оны Авлигатай тэмцэх, шударга ёс, ил тод байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хүргүүллээ.

Хавсралт 4 хуудастай.

ДАРГА Д.ГАНБАЯР



ДАРХАН-УУЛ АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

2020.12.11 № 1024
танай ____-ны № ____-т

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ГАЗАРТ

Тус байгууллагын 2020 оны Авлигатай тэмцэх, шударга ёс, ил тод байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хүргүүллээ.

Хавсралт 4 хуудастай.

ДАРГА Д.ГАНБАЯР

Аймгийн ГХБХ [illegible] р, нягт [illegible] ар 2020 оны санхүүгийн үйл а[illegible] эг зурж [illegible] -ний өдрөөр санхүүгийн байд[illegible] болсон [illegible] аны үр дүн, мөнгөн гүйлгээг [illegible] ьд үнэ[illegible] ийн тухай” хуулийн заалты[illegible] нягтлан бодох бүртгэлийн болон улсын стандартын дагуу бэлтгэн ажиллаа. Тус байгууллага нь тайлант жилийн хугацаанд Газрын дарга, гүйцэтгэх, үйлчилгээний ажилтан гэсэн бүтэцтэйгээр, удирдах ажилтан 1, гүйцэтгэх ажилтан 19, үйлчлэх ажилтан 2 нийт 22 орон тооны бүрэлдэхүүнтэй албан үүргээ гүйцэтгэлээ.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН **100190029001** ДАНСНЫ ТУХАЙ

2020 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн Сангийн яамнаас :

- Тусгай зориулалтын сангаас 314,1 сая төгрөгийн,
- Орон нутгийн төсвөөс 9,8 сая төгрөгийн
- Нийгмийн Даатгалын сангаас 1,7 сая төгрөгийн санхүүжилт,

- ГЗБГЗЗГазраас Хөрөнгийн санхүүжилтээр 9,7 сая төгрөгийн бараа материал агентлагаас захиалж ханган нийлүүлж албан хаагчдын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл бололцоогоор хангасан. Үүнд:
  - нууцлал бүхий цаас – 4260 ш
  - ААНБ-ын газар эзэмших эрхийн гэрчилгээ – 500 ш
  - Төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ – 600 ш
  - Газар эзэмших ГБХ эрхийн гэрчилгээ – 1200 ш
  - Төрийн байгууллагын ашиглах эрхийн гэрчилгээ – 100 ш

2020 оны байдлаар олгогдсон 325,5 сая төгрөгийн санхүүжилтийн 74.8% нь цалингийн сан эзэлж байна.



Батлагдсан төсвийн хуваарийн дагуу Төрийн сангийн 100190029001 дансаар 325,5 сая төгрөгийн санхүүжилт авч 324,0 сая төгрөг зарцуулж ажиллаа.



2020 оны 1-12-р сарын Төсвийн санхүүжилт, зарцуулалтын тайланг өссөн дүнгээр сар бүрийн 01-ны байдлаар гаргаж тогтмол боловсруулж САРЫН мэдээг аймгийн Төрийн сан банкинд цаасан хэлбэрээр хүргүүлэн зардал болон үлдэгдлийг баталгаажуулсан. Хүлээн авсан гарын үсэг тамгаар баталгаажуулан ГЗБГЗЗГазарт цахим болон факсаар хүргүүлсэн.

Сарын мэдээнд:

- Үндсэн үйл ажиллагааны дансны
- Нэмэлт санхүүжилтын дансны
- Мөнгөн кассын тайлан
- Кассын дансны хуулга зэргээс бүрдэн тайлагнадаг. **Нийт 12 удаа мэдээлсэн.**

Төсвийн ил тод, Шилэн дансны хуулийг мөрдөж сар бүрийн 2-ны дотор төсвийн гүйцэтгэлийн мэдээг аймгийн Төрийн сангийн хэлтэст тайлагнахаас гадна www.shilendans.gov.mn сайтад нийт 12 удаа шивж оруулсан. Үүнээс гадна Төсвийн ил тод хуулийг мөрдөж сар бүрийн 2 дансны орлогыг ангилж боловсруулсан мэдээ, эхний хагас жилийн тайланг төрийн сангаар баталгаажуулан ГЗБГЗЗГазарт цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлсэн. Санхүүгийн тайланг санхүүгийн мэдээллийн самбарт байршуулан нийтэд тогтмол шинэчилэн ил тод мэдээлж байна. Албаны сайтад сарын мэдээг скайнердан pdf файлаар хавсаргаж мэдээлсэн.

Цаг үеийн мэдээ тайлангуудыг заагдсан хугацаанд багтааж гүйцэтгэлийн тайлан, хугацаат мэдээ, судалгаануудыг холбогдох газруудад хүргүүлэн ажиллаж байна.

Төрийн албан хаагчийн цалин хөлс, нэмэгдлийг хууль тогтоомжийн дагуу хугацаанд нь бүрэн олгож ажилласан. ГХГЗЗГазрын даргын 2019 оны Б/123 дугаар тушаалыг үндэслэн 2020.01.02-ний өдрөөс нийт 22 ажилтан албан хаагч ажиллаж байна. Байгууллагын албан хаагчдын цалинг сард 2 удаа тогтоосон хугацаанд /Сар бүрийн 10, 25-нд/ олгож, албан хаагчдын сарын цалин, тэтгэмж, урамшуулал, хоол унааны хөнгөлөлтийг олгож ажиллаж байна. Гэрээний дагуу ХААН банкаар цалинг олгож байсан ба 2020 оны 09-р сарын 1-ний өдрөөс Төрийн албаны цалингийн нэгдсэн системээр олгож эхэлсэн. ТАЦНС нь Хүний нөөцийн удирдлагын системтэй нягт холбоотой бөгөөд албан хаагчдын мэдээллийг бүрэн агуулсан систем юм. 2019.12.25-ны өдрийн МУ-ын ЗГ-ын 24 дүгээр тогтоолын дагуу /Төрийн албан хаагчийн цалингийн

сүлжээг шинэчлэн тогтоох тухай/ 2020.01.01-ны өдрөөс албан хаагчдын цалинг нэмэгдүүлэн олгож байгаа.

Мөн жилийн эцсийн байдлаар байгууллагын албан хаагчдын буюу даатгуулагч нарын цалингийн НДШимтгэлд өссөн дүнгээр 32,360.0 төгрөг шилжүүлсэн. Эрүүл мэнд, НДШимтгэлийн тооцоо тайланг сар бүр даатгуулагч бүрийн мэдээллийг www.ndaatgal.mn сайтад бүртгэлийн дагуу онлайнаар тайланг шивж илгээх буюу мөн цаасан хэлбэрээр баримтжуулж тайлагнасан. Сар бүрийн 5-ны дотор ажилтан бүрийн цалингийн нийгмийн даатгалын шимтгэлийг Маягт НД-7, НД-8–ын дагуу **12 удаа** хийж гүйцэтгэсэн. Тайлангийн дүнгээр нийт 22 ажилтны НД дэвтэрт сар бүр бичилт хийж, улирал бүр баталгаажуулж ажиллаа.

Татварын хэлтэст дараах 5 төрлийн тайланг заагдсан хуулийн хугацаанд хийж гүйцэтгэсэн. Үүнд:

a. Цалин хөдөлмөрийн хөлс тэдгээртэй адилтгах орлого болон шууд бус орлогоос суутгасан албан татварын тайлан, /Улирал бүр нийт **4** удаа/

b. Газрын төлбөрийн тайлан /Улирал бүр **4** удаа/

c. Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах зөвшөөрөл олгох, газрын хэвлийг олгоход хураах улсын тэмдэгтийн хураамжийн тайлан /Хагас жил бүр нийт **2** удаа/ тус тус тушаав.

Аймгийн Татварын хэлтэст жилийн эцсийн байдлаар /2020.12.31-ний гүйцэтгэлээр/ **16.9 сая** төгрөгийн цалингийн ХХОАТатвар шилжүүлсэн байна.



Татвар, нийгмийн даатгал болон дансны өр авлагагүй ажилласан.

Тоёото Беривис маркийн суудлын автомашинаар тооцоо хийж байна. Жолоочтой шатах тослох материалын тооцоог дараа сар 1-н бүрээр тасалбар болгон замын хуудас холбогдох материалыг хүлээн авч тооцоо бодож түүнийг үндэслэн ирэх сарын гүйлгээний баримтыг цаг тухайд нь хийж шатахуун олгох ажлыг зохион байгуулж, автомашины хувийн хэрэг хөтөлж байна. Мөн шаардахаар жолооч болон байгууллагын албан хаагчдад шатах тослох материалын **7,7 сая** төгрөгийн талон олгож гүйцэтгэлийг сар бүрийн эцсээр тайлан гаргуулсан.

Албан томилолтыг МУ-н Сангийн Сайдын 2018.12.27-ны №301 тоот тушаалаар /Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай/, МУ-н Засгийн газрын 2019.01.09-ны 6 тоот тогтоол / Журам шинэчлэн батлах тухай/-ын дагуу анхан шатны баримтыг үндэслэн тооцож томилолтын мөнгийг тооцож даргаар баталгаажуулан тухайн албан хаагчийн дансаар шилжүүлж,олгож байна. Томилолт олгосон хугацааны хоол унааны мөнгө цалингийн хоол унааны хөнгөлттэй давхардаж олгогдоогүй. Эхний хагас жилийн байдлаар нийт албан хаагчдад **524.0** төгрөгийн томилолтын мөнгө томилолтоор ажилласан тайланг тухай бүр гаргуулан авч олгосон. Ковид – 19 цар тахал тархсантай холбоотой тухайн зардлын дансыг тодорхойгүй хугацаагаар хаасан. Газрын даргын 2020 оны Б/01 дугаар тушаалын хуваарийн дагуу ээлжийн амралтыг биеэр эдлүүлэхээр нийт **22** албан хаагчдын ээлжийн амралтын олговрыг тухай бүр нь олгосон байна. Амралт авахын өмнө орлон гүйцэтгэх ажилтантай ажлаа хүлээлцэх тойрох хуудас бөглөн ээлжийн амралтын цалинг олгодог.

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ **ОРЛОГЫН 100190029003** ДАНСНЫ ТУХАЙ

Төрийн сан банкны 100190029003 тоот дансаар орох Төсвийн орлогын төлөвлөгөө 2020 онд газрын үйл ажиллагааны орлогоос 60,0 сая төгрөг оруулах төлөвлөгөөтэй. Үүнээс: 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Газрын хуульд заасан хэлбэрээр эзэмших

- гэрчилгээний орлого – 11,2 сая төгрөг,
- кадастрын зураглалаар – 7,9 сая төгрөг,
- нэгж талбарын хувийн хэрэг - 16,2 сая төгрөг,
- Барилга захиалагчийн хяналтын орлого – 29,9 сая

нийт 65,0 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого орсон.

Дээрх нийт үйл ажиллагааны орлогыг сар бүрээр ангилан төсвийн ил тод самбарт шинэчилэн мэдээлж байна.

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТЫН **100190029401** ДАНСНЫ ТУХАЙ

Аймгийн Төрийн сан банкны 100190029401 тоот нэмэлт санхүүжилтийн дансаар 2020.12.31-ны байдлаар 137,3 сая төгрөгийн дуудлага худалдаа болон газрын анхны үнийн орлого орсон. Үүнээс 2020 оны эхний хагас жилийн байдлаар Газар эзэмших эрхийн гэрчилгээний ДУУДЛАГА ХУДАЛДАА зохион байгуулагдаж иргэн, ААНБ-ын хүсэлтын дагуу 11,3 сая төгрөгийн дуудлага худалдаанд ялагдсан иргэн, аж ахуй нэгжид дэнчингийн мөнгийг буцааж олголоо. Дэнчингийн мөнгийг баталгаатай дансдуудаар буцаан шилжүүлсэн болно. Үүнд иргэн ААНБ-аас хүсэлт, гэрчилгээний баталгаажсан хуулбар, данс нотолсон баримтыг хүлээн авч дэнчин буцаах гүйлгээ хийгдэж байна.

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ

ГХБХБГ-аас төрийн үйлчилгээг ил тод болгох Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж тухай бүр болон сар улирал, жилийн мэдээ тайланг ГХБХБГ-ын төсвийн ил тод самбарт болон www.darkhan.gazar.gov.mn цахим хаягт мэдээлж байна. Мөн албаны сайтад шилэн дансыг холбон мэдээлэв.



Байгууллагын төв хаалганы дэргэд санхүүгийн ил тод байдлын самбар ажиллуулж сар бүр орлого зардлын мэдээг шинэчилж байршуулсан. Шилэн дансны хуулийн дагуу иргэдэд долоо хоног, сар, улирал, жилийн төсөв мөнгө хөрөнгөтэй холбоотой тушаал, төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг шинэчилж шивэн оруулж файлаар хавсаргасан.

2020 оны эхний хагас жилийн байдлаар 68 удаагийн мэдээллийг мэдээллийн самбарт байршуулж иргэдэд мэдээлсэн байна.

2020 оны эхний хагас жилийн байдлаар 144 удаагийн мэдээллийг шилэн дансанд оруулж иргэдэд мэдээлсэн байна.

Нэр	Мэдээлэл оруулах давтамж	Нийт мэдээллэх	
Дараа жилийн төсвийн төсөл	Бүтэн жил	2	Хуулийн хугацаанд нь мэдээлсэн.
Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	Тухай бүр	12	Хуулийн хугацаанд нь мэдээлсэн.
Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл	Тухай бүр	12	Тендерийн арга хэмжээ байхгүй байхгүй тухай мэдээлсэн.
Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл	Тухай бүр	12	Тендерийн арга хэмжээ байхгүй байхгүй тухай мэдээлсэн.

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	Тухай бүр	12	Хуулийн хугацаанд нь мэдээлсэн.
Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ	Тухай бүр	12	Цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш орлого зарлагыг мэдээлсэн.
Санхүүгийн тайлан	Хагас жил	2	Хагас жилийн тайланг шилэн дансанд мэдээлсэн.
Худалдан авах ажиллагааны тайлан	Хагас жил	6	Худалдан авах ажиллагаа байхгүй тухай мэдээлсэн.
Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт	Сар бүрийн 8-ны дотор	6	8 удаа шилэн дансанд мэдээлсэн.

Байгууллагын ЭБАТ-аас- Ашиг сонирхолын зөрчилгүй гэсэн мэдэгдлийг хүлээн авч шилэн дансанд PDF файлаар **12 удаа** мэдүүлэв.

Аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг, ГХБХБГ-ын даргын өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай үед нь хэрэгжүүлэн, иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн

хугацаатай, хариутай албан бичиг, мэдээ тайланг тухайн цаг хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн.

ГЭРЭЭТ АЖИЛ:

Тэнгэрийн бүргэд ХХК-тай 2019 оны 11 дүгээр сарын 01-ний №03 тоот харуул хамгаалалтын гэрээгээр харуул Р.Цэнгэлсайхан ажиллаж байна.

Говийн наран сүлд ХХК-тай 2019 оны 01-р сарын 02-ны №2019/02 тоот гэрээгээр байгууллагын автомашиныг гаражаар хангаж ажиллаж байна.

Санхүүгийн тайланг Улсын Секторын Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийг хэрэглэсэн болно.

Улирал жилийн тайлан, тэнцлийг хийж гүйцэтгэн хянуулах, гүйлгээ баланс, журнал, дэлгэрэнгүй бүртгэл, хөрөнгийн тодруулгыг гарган тулган шалгуулж баталгаажуулсны дараа нэгтгэлийн тайланд өгдөг.

2020 оны жилийн эцсийн баланс, тайлан тэнцлийг Сангийн яамны сайтны e-tailan–д хуулинд заагдсан хугацаанд нэгтгүүлэв.

Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг Санхүү эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 тоот тушаалаар батлагдсан маягт зааврын дагуу хөтөлж байгаа. Санхүү төсвийн сахилгын зөрчилгүй ажилласан.

Бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартад нийцсэн нэгдсэн программд оруулж тайлагнадаг. Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан тэнцэл гаргахад санхүүгийн “ACOLOUS” программыг үр дүнтэй ашиглан ажиллаж байна.





Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй боловч завсарлах, ашиглагдах боломжгүй хөрөнгүүдийн жагсаалтыг гарган Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүсэлт

илгээн зөвшөөрлийг авч 8 нэр төрлийн 2,6 сая төгрөгийн хөрөнгийг акталж устган тайланг хугацаанд нь гарган хүргүүлсэн. Мөн Хьндай Санта Фе 0 маркийн автомашиныг ТӨБЗГазрын 459 дүгээр тогтоолын дагуу дуудлага худалдаагаар худалдан орлогыг холбогдох данслуу шилжүүлж хөрөнгийг данснаас хассан.

Бараа материалын хувьд эхэлж авсанаа эхэлж зарлагадах аргыг ашиглаж байна. Бараа материалын оны эхний үлдэгдэл 38,7 сая төгрөг, ГЗБГЗЗГазраас үнэ төлбөргүй буюу шилжүүлэн авсан хангамжийн материал, үнэт цаас хөрөнгийн санхүүжилт, өөрийн санхүүжилтээр авсан бараа материал зэрэг 48,1 сая төгрөгийн орлого авч, шаардах хуудсаар олгосон бараа материал 45,3 сая төгрөгийн зарлага, 41,5 сая төгрөгийн үлдэгдлээр данс бүртгэлтэй байна.

2020 оны 2-р сараас Ковид-19 цар тахал гарсантай холбоотой Сангийн яамнаас зарим зардлын дансыг түр хугацаагаар хаасан. Мөн цар тахалтай холбоотойгоор албан хаагчдыг дархлаажуулж, ариутгал халдваргүйжүүлэлтийн материалыг хүн тус бүрд нь олгосон. Байгууллагын ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг байнга хийлгэн нөөцийг бүрдүүлж ажилласан.

Нярав:

Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд 6904 ширхэг кадастрын цаас, 835 ширхэг НТХХ, 848 ширхэг газар эзэмших гэрчилгээ /Иргэн/, 163 ширхэг газар эзэмших гэрчилгээ /ААНБ/, 18 ширхэг газар эзэмших гэрчилгээ /ТБ/, 10 ширхэг газар ашиглах гэрчилгээ /ААНБ/, Хонгор сумын даамалд 1220 ширхэг кадастрын цаас, 515 ширхэг газар эзэмших гэрчилгээ /Иргэн/, 100 ширхэг газар эзэмших гэрчилгээ /ААНБ/, 1 ширхэг газар ашиглах гэрчилгээ /ААНБ/, Орхон сумын даамалд 560 ширхэг кадастрын цаас, 111 ширхэг газар эзэмших гэрчилгээ /Иргэн/, 14 ширхэг газар эзэмших гэрчилгээ /ААНБ/, 10 ширхэг газар эзэмших гэрчилгээ /ТБ/, 92 ширхэг НТХХ хавтас, Шарын гол сумын газрын даамалд 60 ширхэг кадастрын үнэт цаас, 57 ширхэг газар эзэмших гэрчилгээ /Иргэн/, 9 ширхэг газар эзэмших гэрчилгээ /ААНБ/, 2 ширхэг газар эзэмших гэрчилгээ /ТБ/ тус тус олгов.

Шаардах хуудсаар 150 төрлийн 1209 ширхэг бараа материал олгов.

2019 оны 12-р сар, 2020 оны 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11-р сарын үнэт цаас, улсын тэмдэгтийн хураамж, бараа материалын зарцуулалтын тайланг нэгтгэж ня-бод өгөв.

Агентлагаас ирсэн болон шинээр авсан бараа, материалыг хүлээн авч, бүртгэн агуулах доторх шинээр ирсэн бараа материал, үнэт цааснуудыг цэгцлэв.



Үндсэн хөрөнгө, бараа материалын картанд өөрчлөлтүүдийг хийж хэвлэн, эд хариуцагчдаар гарын үсэг зуруулж, нягтлан бодогчид өгөв. Үндсэн хөрөнгө хүлээн авч, мэргэжилтнүүдэд шилжүүлэх гэрээг бичив. Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтнүүдтэй хамтран барилгын чиглэлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг мэргэжилтнүүдэд хуваарилж үндсэн хөрөнгө болон бараа материалын картуудыг шинэчлэн хэвлэж, гарын үсэг зуруулав.

Байгууллагын үндсэн хөрөнгийг кодлож, бүртгэлийг сайжруулах ажлын хүрээнд байгууллагын шүүгээ, ширээ, сандал, тумбочка, компьютер, хэвлэгч, сканер зэрэг дагалдах төхөөрөмжүүдийг нэг бүрчлэн кодлов.

2019 оны газар эзэмших эрхийн гэрчилгээ, улсын тэмдэгтийн хураамжийн /ААНБ, ТБ/, газар ашиглах эрхийн гэрчилгээ, улсын тэмдэгтийн хураамжийн /ААНБ/ тайлан, Дархан-Уул аймгийн 1-4-р сарын Нэгж талбарын хувийн хэргийн хавтасны зарцуулалтын тайлан, 2019 оны сүүлийн хагас жил, 2020 оны 1-р улирлын кадастрын үнэт цаасны зарцуулалтын тайлан, 2020 оны 5-9-р сарын НТХХ-ны зарцуулалтын тайланг нэгтгэж, үдэж, хавтаслан, хуудас дугаарлаж, архивт хүлээлгэн өгөв. 2020 оны 1-6-р сарын газар эзэмших гэрчилгээ /Иргэн/-ний зарцуулалтын тайланг нэгтгэж, үдэн хуудсуудыг дугаарлаж, албан хэрэг хөтлөлт хийж архивлав.



Хонгор, Орхон, Шарын гол сумдын газрын даамлуудаас үнэт цаасны зарцуулалтын тайлан хүлээж авч, баримттай нь тулгаж шалгав.

СУРГАЛТ

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Геодези, зураг зүйн хэлтэсээс зохион байгуулсан “Геодезийн байнгын цэг тэмдэгтийн цахим санг 2020 оны 1-р улиралд багтаан хэрэглээнд нэвтрүүлэх”-тэй холбогдуулан аймаг, нийслэлийн геодези зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэнгүүдийг хамруулан 2020 оны 01 сарын 15-26-ны хооронд хийсэн сургалтанд хамрагдсан.

НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагаас зохион байгуулж буй Дэлхийн хөрсний давсжилтийн зураг хийх онлайн сургалт /Италын Ром хотоос/-ыг Дэлхий 13 улсад явуулж байгаа бөгөөд энэ сургалтанд Монгол улсын талаас ГЗБГЗЗГ-аас Суурь судалгаа, мониторингийн хэлтсийн мэргэжилтэн Д.Мөнхцэцэг, Дархан-ХААИС-ын багш, доктор профессор Б.Энхтуяа, Дархан-УГТЭШХ-ээс хөрсний лабораторийн эрдэм шинжилгээний ажилтан н.Мөнхбат, мөн миний бие 2020.03.24-04.03-ны өдрүүдэд сургалтанд амжилттай оролцож, сертификатыг мэйлээр хүлээн авсан.



НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага болон ГЗБГЗЗГ-ын хооронд 2019.12.30-ний өдрийн 2019/92 дугаартай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Энэ ажлын хүрээнд "Үндэсний хэмжээний газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлтийн үнэлгээ" хийх ажлыг 21 аймаг болон нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Суурь судалгаа, газрын мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд хоёрдугаар шатны Openforis, Collect earth программын сургалтыг 2020.04.01-03-ны өдрүүдэд цахимаар 8.30-17.30 цагийн зохион байгуулж үүнээс Дархан-Уул аймаг 2020.04.01-02-ны өдрүүдэд уг программын сургалтанд оролцсон.

ГЗБГЗЗГ-ын ОЗМТХ-ээс 5 сарын 12-ны өдөр БНХАУ-ын ZY-3 хиймэл дагуулын 2.1 метрийн нарийвчлалтай панхроматик, үзэгдэх гэрлийн 5.8 метрийн нарийвчлалтай сансрын зургийг хүлээн авч байгаатай холбогдуулан ZY-3 хиймэл дагуулын тоог өгөгдлийг боловсруулах тухай цахим сургалтыг 21 аймгийн мэргэжилтнүүдэд хийсэн.

НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага болон ГЗБГЗЗГ-ын хооронд 2019.12.30-ний өдрийн 2019/92 дугаартай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Энэ ажлын хүрээнд "Үндэсний хэмжээний газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлтийн үнэлгээ" хийх ажлыг 21 аймаг болон нийслэлийн газар зохион байгуулалтын албаны суурь судалгаа, газрын мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд 2020.05.20-21-ны өдрүүдэд Collect earth программын ахисан түвшний сургалтыг цахимаар зохион байгуулсан.

Байгаль орчин, аялал жуучлалын яам Даян дэлхийн байгаль орчны сангийн дэмжлэгтэйгээр НҮБ-ын ХХААБ-тай хамтран "Парисын хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсын тодорхойлсон хувь нэмрийн зорилтын хэрэгжилтийг Хөдөө аж ахуй, ой бусад

газар ашиглалтын салбарт ил тод байдлаар тайлагнах, мониторлох үндэсний чадавхыг бэхжүүлэх нь төслийн хүрээнд 2020.09.14-ны өдөр цахим зөвлөгөөнд оролцсон.



Барилга, хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төв, Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбооноос зохион байгуулсан 2020.10.05-2020.10.07 хооронд Архангай аймгийн цэцэрлэг суманд зохион байгуулагдсан “Барилгын материал үйлдвэрлэлийн улсын анхдугаар зөвлөгөөн”-д Барилга, хот байгуулалтын хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Дархан хот байгуулалт, барилга захиалагч газар ОНӨААТҮГ-тай хамтран оролцсон.

2020.10.22-23 өдрүүдэд Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас зохион байгуулсан хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд инженерийн шугам сүлжээ, ногоон байгууламжийг бүртгэх талаар суралтанд оролцсон.

Барилгын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх ажлын зөвшөөрөл олгох цахим программ хангамжийн сургалт зохион 2020.06.15-2020.06.17-ны өдрүүдэд ГЗБГЗЗГ-ны холбоходох мэргэжилтэнгүүд ирж сургалт зохион байгуулсан.Сургалтанд аймгийн Ерөнхий архитектор, барилга хот байгуулалтын хэлтсийн холбогдох мэргэжилтэнгүүд хамрагдсан.

Дархан дагуул хот төслийн хүрээнд төрийн албан хаагчийг чадавхжуулах ArcGIS программын 14 хоногийн сургалттанд сууж төгссөн.

Удирдлагын академиас зохион байгуулсан Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх сургалтанд сууж 11 кредит цуглуулан 11 сарын 02 эхлэн 12 сарын 10 хооронд танхимаар болон цахим хэлбэрээр сургалтанд сууж төгссөн.

2020 оны 10-р сард Хэлний бодлогын Үндэсний зөвлөлийн Дархан салбараас зохион байгуулсан “Миний нэрийн хуудас- Нэр төрийн баталгаа” аянд нэгдэж, сургалтанд хамрагдсан.

БУСАД АЖИЛ

Дархан сум 9,10,12,15 дугаар багуудын нутаг дэвсгэр 31 дүгээр хороололд 04 сарын 26-29-ны хооронд 425 айлын амины орон сууцны зориулалтаар олгогдох газарт 726 цэгийг тэмдэглэж улаан шугам тавиж газар дээр тэмдэгжүүлж

Аймгийн Засаг даргын тамгын газраас ирүүлсэн албан бичгийн хүрээнд 2020.10.19-нд Орхон сумын нутаг дэвсгэрт ногоо хураалтын намрын ажилд хамт олноороо идэвхитэй 3 өдөр ажиллаа.

ДАРХАН-УУЛ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

45050 Дархан-Уул аймаг
Утас: 7037-7323, Факс: 7037-7121,
И-мэйл: info@darkhan.gov.mn
Вэбсайт: www.darkhan.gov.mn

2020.10.07 № 2-10/1137
тамаг хүчин № хуудсан

АЛБАН БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖИЙН ДАРГА НАРТ

Намрын ногоо хураалтын ажил Орхон суманд 2020 оны 10 дугаар сарын 09-ний өдрөөс 11-ний өдрүүдэд болох тул албан байгууллага, аж ахуйн нэгжүүдээс хүний нөөцөд тулгуурлан дээрх ажилд оролцуулах хүмүүсийн тоог хавсралтаар баталж хүргүүлнэ.

Зохион байгуулалтын арга хэмжээ авч, хүмүүсээ чөлөөлөн оролцуулж, дэмжлэг үзүүлэн хамтран ажиллана уу.

Жич: 1 өдрийн ажлын хөлс 25000 төгрөгийг тухайн ажиллах хүч авсан аж ахуйн нэгж хариуцна.

Хавсралт: 2 хуудастай.

ДАРГА Ч.ЭНХБАТ

4520102250

2020 Тоо-2

2020.10.16-2020.10.21 хооронд байгууллагын гаднах доторхи их цэвэрлэгээний ажлыг байгууллага хамт олноороо хийж гүйцэтгэсэн.

КОВИД-19 цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Шинэ төрлийн коронавирусын дэгдэлт дэлхийн улс орнуудад тархаж байгаатай холбогдуулан урьдчилан сэргийлэх чиглэлээр албан хаагчдад цаг тухайд нь эх сурвалжаас үнэн бодит мэдээлэл, эрүүл мэндийн газраас хэрэгжүүлж буй урьдчилан сэргийлэх талаарх зөвлөмжийг байгууллагын мэдээллийн самбар, вэб сайт, нүүр номоороо мэдээллүүдийг тогтмол шуурхай авч, МУЗГ-ын 30 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын хуралдааны тэмдэглэл, аймгийн Засаг даргын албан даалгавар зэргийг шуурхай хурлаар үүрэг даалгавар болгон ажиллаж байна.

Аймгийн онцгой комиссын мэдээллийг 7 хоног бүрийн баасан гаригт АВЛЕ системээр Гамшгаас хамгаалалт, төлөвлөлтийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Дэд хурандаа С.Мөнхбат хүргүүлэв.

Засгийг газрын тогтоол, Улсын онцгой комиссын шийдвэр, аймгийн Засаг даргын захирамжын дагуу байгууллагын албан хаагчдын цагийн бүртгэлийг өдөр бүрээр нь цаасаар бүртгэж гарын үсэг зуруулж ажилласан, Дарханчууд хамтдаа коронавирусын эсрэг аянд байгууллагаар нэгдэж, нийт 22 албан хаагчид нэг өдрийн цалин 725,000 төгрөгийг аймгийн Онцгой комисст хандивласан.

Дархан-Уул аймгийн Улаан загалмайн хорооноос ОУ-ын Улаан Загалмайн хөдөлгөөний үндсэн зарчмууд, Гамшгаас хамгаалах хууль, эрүүл мэндийг дэмжих, амьдралын чанарыг сайжруулах, цусны авлагагүй донорын эгнээг нэмэгдүүлэх, гамшгийн эрсдлийг бууруулах даван туулах чадварыг бэхжүүлэх, сургалт сурталчилгааг зохион байгуулах, шаардлагатай үед сэтгэл зүйн болон эд материалын тусламж үйлчилгээг үзүүлэх талаар албан хаагчдад танилцуулж, хүмүүнлэгийн үйлсэд дэмжлэг туслалцаа үзүүлэх, гишүүдийн хандиваар үйл ажиллагаагаа зохион байгуулдаг тухай ойлголтыг хүргэсний дагуу 2020 онд тус хорооны үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллаж, гишүүн байгууллагаар элслээ.



Улаан загалмайн хорооноос байгууллагын нийт албан хаагчдад шинээр тархаж буй коронавирус, бусад томуугийн халвараас урьдчилан сэргийлэх зорилготой 14 хоногийн

хэрэглээний маск-250 ширхэг, гар ариутгагч гель 1литр 1ширхэг, 30 ширхэг жижиг 55 мл санитас, 2 саван, зөвлөмжийн талаарх плакат 4 ширхэг зэргийг тарааж ажиллаа.

Мөн МУЗН-тай хамтран амжиргааны түвшин доогуур өрх толгойлсон олон хүүхэдтэй 3 иргэнд 1 сарын хүнсний өргөн хэрэглээний бараа материалыг гардуулж өгсөн.

Дархан-Уул аймгийн Улаанзагалмайн хорооны дарга Б.Отгонбаяр нь Гишүүн байгууллагын Батламж болон нийт 22 албан хаагчдад гишүүний үнэлэх, гарын хөөсөн саван 5 ширхэг /300гр/, гар ариутгагч 5 ширхэг /500 гр/ зэргийг олгов.

Албан хаагдчын эрүүл мэндийн сайжруулах, дархлааг сэргээж өдөрт халуун аарцыг тогтмол уулгадаг, өглөөний дасгалыг 15 минутаар бүх албан хаагчдаар хийлгүүлж тогмол хэвшүүлж, өглөө бүр халууныг үзэж, хяналт тавьж байна.

ЕБС, СӨББ-ын үйл ажиллагааг түр зогсоосонтой холбогдуулан байгуулагын эцэг, эхийн зөвлөлийн санаачлага болон албан хаагчлын хүсэлтийн хүрээнд 0-10 настай хүүхэдтэй

албан хаагчдын судалгааг гаргаж, хүүхдийн эрхийг хангах тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэх үүднээс 2020 оны 02 дугаар сарын 17-оос 2020-оны 03 дугаар сарын 02-ны өдрийг хүртэлх ажлын 7 өдрийг ГХБХБГДаргын тушаалаар богиносгосон цагаар ажиллуухаар шийдвэрийн төсөл боловсруулж батлуулсан. ГХБХБГ-ын даргын 2020 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн А/03 тоот тушаалаар 2020 оны 02 дугаар сарын 17-оос 2020-оны 03 дугаар сарын 02-ны өдрийг хүртэлх ажлын 7 өдрийг ажлын тусгай горимд шилжүүлэн ажлуулах аймгийн Засаг даргын захирамжыг үндэслэн ажлын цагийг 7 цагаар тооцон ажиллуулан, цагийн бүртгэлийг цаасаар гарын үсэг зурж баталгаажуулан ажиллаж байна.

Мэдээллийн хэрэгсэл болох телевиз, утсаар эрүүл мэндийн яам, улсын онцгой комиссоос анхааруулж буй мэдээлэл, зөвлөмжийг даган ажилласан, байгууллагын ОО, өрөө тасалгааг өдөрт 3 удаа байнгын цэвэрлэгээ хийж, агаар салхивчаа тогтмол нээж, үүдэнд орж ирж байгаа үйлчлүүлэгчдийн гарыг ариутгаж, мөн маскыг тогтмол зүүж хэвшүүлэх зэргээр зөвлөмж, анхааруулгыг хүргэж ажиллаа.

Ариутгал халдваргүйжүүлэлтийг байгууллагын эргэн тойрон болон пудвол, 00 зэргийг ариутгасан

Улсын онцгой комисс болон аймгийн Онцгой комиссоос өгсөн үүрэг даалгаварын дагуу газрын даргын 5 тушаалыг гарган албан хаагчдад мөрдүүлэн ажиллаа.

Газрын даргын тушаалын дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Хариуцлагатай жижүүрээр томилогдсон албан хаагчид ажлын хуваарийг 05 дугаар сарын 31-нийг хүртэлх хугацаагаар сунгасан. Улсын онцгой комиссоос 3 хоногийн хугацаанд цар тахлын үеийн сургуулалтыг аймгийн шуурхай штабын ажлын хэсгийн үйл ажиллагаанаас туршлага солилцож албан хаагчдыг бэлэн байдлын хангуулж, өглөөний 06 цагаас орой 23 цаг хүртэлх хугацаанд албан хаагчдаа 4 хуваан ажиллуулж байна.

Шинэ төрлийн коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Онцгой комиссоос өгөгдсөн үүрэг чиглэлийн дагуу газрын даргын тушаалаар “Нийтийн Эргүүл” хийх албан хаагчдын байршил хугацааг зааж, 4 өдрийн эргүүлийн тайланг хүргүүлсэн.

2020.11.17-ны өдөр Дархан сумын 9, 10-р багийн иргэдэд захиалгаар хүнсний бүтээгдэхүүн хүргэх тусгай зөвшөөрөл олгох дэлгүүрүүдрүү холбогдож, бүртгэл хийсэн. 2020.11.18 - 2020.11.20-ны өдрүүдэд 08:00– 23:00 цагийн хооронд http://huns.smartdarkhan.com/ цахим хаягт ирсэн иргэдийн захилгыг тухай бүрт тусгай зөвшөөрөлтэй хүнсний дэлгүүрүүдэд хуваарилан утсаар холбогдож, захиалгыг онлайнаар шилжүүлж 2 цаг тутамд хүргэлтийн тоо мэдээг нэгтгэн ажилласан.

Мөн 2020.11.21-2020.11.28-ны өдрүүдэд Дархан сумын 9, 10-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулсан 17 дэлгүүрээс ажилласан хүний тоо, үйлчлүүлсэн хүний тоо, орлогын мэдээллийг авч нэгтгэн, аймгийн шуурхай штабд мэдээлж байв.

2020.11.24 – 2020.11.26-ны өдрийн 08:00 – 24:00 цагийн хооронд “1 өрх, 1 иргэн” PCR шинжилгээний Дархан сумын 8-р багийн иргэдийн 1611 шинжилгээний бүртгэл, тоо мэдээ, зохион байгуулалтын үүргийг хариуцан ажилласан.

Дархан-Уул аймагт байгаа Сэлэнгэ аймгийн иргэдийг нийтийн тээврээр буцаах ажлын хүрээнд 2020.11.29 - 2020.12.02-ны өдрүүдэд Нийтийн унаагаар явах хүсэлтэй Сэлэнгэ аймгийн 17 сумын цахимаар бүртгүүлсэн 651 иргэдийн судалгаан дээр ажиллаж, тоо мэдээ гарган, нэмэлтээр бүртгүүлсэн 94, нийт 745 иргэдрүү тус бүр 2-3 удаа утсаар ярьж, шинжилгээ өгсөн эсэх талаар лавлан, явах цаг байршлын талаар мэдээлэл олгож ажилласан. Мөн Сэлэнгэ аймагруу 2020.12.03-ны 08:30 – 17:00 цагийн хооронд 329 иргэн, 2020.12.04-ны 11:00 – 19:00 цагийн хооронд 219 оюутнуудыг буцаах ажлын бүртгэл, зохион байгуулалтын ажлыг хамт олноороо гүйцэтгэсэн.

Улаанбаатар ирэх авто машинтай иргэдийн цувааг урд постноос тосон авч Сэлэнгэ явах хойд поструу хүргэх ажлыг 2020.12.11-2020.12.24 өдрийг хүртэл хувиарын дагуу гүйцэтгэж байна.



Улаанбаатар хот руу явахаар хүсэлт гаргасан 50 иргэн рүү утсаар ярьж, шинжилгээ өгөх газар, цагийн талаарх мэдээллийг өгөв. 500 иргэнийг PCR шинжилгээнд хамруулахад бүртгэл дээр ажиллав.

Шинжилгээ өгсөн иргэдийг Улаанбаатар, баруун 7 /Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Архангай, Завхан, Увс/ аймаг руу явуулах бүртгэл дээр бусад төрийн байгууллагуудтай хамтран ажиллав.

Мөн 2020.12.04-ны өдөр Дархан политехникийн коллеж, Дархан дээд сургууль, Мандах бүртгэл дээд сургууль, Уул уурхайн полтехникийн дээд сургууль, Анагаах ухааны их сургуулт, ХААИС, Дархан-Өргөө коллеж, ШУТИС-ийн оюутнуудыг орон нутаг руу явуулах ажлыг байгууллагын албан хаагчид хамтран зохион байгуулсан.

Монгол Улсын хэмжээнд ковид 19 гарсантай холбогдуулан бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Дархан-Уул аймгийн Шуурай штабт Онгой комиссын даргын ажлын зураг, Салхит багийн зураг, Дархан сумын багийн зураг, Дархан-Уул аймгийн хаягийн зураг болон цагийн байдалтай холбоотой зургууд, Шарын

гол сумын шуурхай штабт Шарын гол сумын хаягийн зураг, Шарын гол сумын багийн хилийн зургийг эхийг 180*120 хэмжээтэй бэлдэж өгсөн.



Аймгийн шуурхай штабын жижүүрийн зураг